



# Зөвлөмжийн Цуврал

## ЗЦ108-1

Нэмэлт, өөрчлөлт 1 (3)

**Агаарын тээвэрлэгчийн  
аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр**

**2022 оны 12 сарын 9**

### Ерөнхий зүйл

ИНЕГ-ын зөвлөмжийн цуврал (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмуудын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргуудыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

### Зорилго

Энэ АС нь ИНД-108 Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр, дүрмийн аюулгүйн хамгаалалтын шаардлага, стандартад нийцэх зааварчилгаагаар хангахад оршино.

### Холбогдох дүрмүүд

Энэхүү АС нь ИНД-108 болон дараах дүрмээр шаардсан аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн боловсруулалт;

- ИНД-119-ийн дагуу гэрчилгээ хүсэх агаарын тээвэрлэгч; болон
- ИНД-129-ийн дагуу гэрчилгээ хүсэх гадаадын агаарын тээвэрлэгчид шууд хамаарна.

### Өөрчлөлтийн мэдэгдэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

АС-108-1-ийг англи, монгол хэл дээр боловсруулсан бөгөөд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

Энэхүү АС-108-1-ийг NZ АС108-1-ийн 2013 оны 1 сарын 3-ны өөрчлөлт 3-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

А Бүлэг – Ерөнхий зүйл.....	9
108.1 Хамрах хүрээ.....	9
В Бүлэг - Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлага.....	9
108.51 Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр .....	9
108.51(1) Гэрээний зохицуулалт.....	9
108.51(2) Сургалт .....	9
108.53 Аюулгүйн хамгаалалтын шаардлага- Орон нутаг .....	10
108.53(b)(1) Агаарын хөлөгт галт зэвсэг тээвэрлэх.....	10
108.53 (b)(2) Заналхийллийн эсрэг авах хариу арга хэмжээний журам.....	10
108.53 (b)(3) Үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн аюулгүй байдал .....	11
108.53(b)(4) Аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн хамгаалалттай бүс болон бусад үйл ажиллагааны бүсэд нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих .....	12
108.53(b)(5) Тээш, ачаа, илгээмж, шуудан, агаарын хөлгийн хангалт, нөөцийн хамгаалалт.....	12
108.53(b)(6) Хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх- нислэгийн аюулгүй байдал .....	14
108.53(b)(7) Зорчигч, тээшний тулгалт- агаарын хөлөгт суугаагүй зорчигч.....	16
108.53(b)(8) Зорчигчийн аюулгүйн үзлэгийн үед үүссэн онцгой байдал.....	17
108.53(b)(9) Орон нутгийн нислэгийн тээшний үзлэгийн үед үүссэн онцгой байдал.....	18
108.53(b)(10) Аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэн .....	18
108.53(b)(11) Агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэх.....	18
108.55 Аюулгүйн хамгаалалтын шаардлага- Олон улс.....	19
108.55(b)(1) Агаарын хөлөгт галт зэвсэг тээвэрлэх.....	19
108.55(b)(2) Заналхийллийн эсрэг авах хариу арга хэмжээний журам.....	20
108.55(b)(3) Үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалт ....	21
108.55(b)(4) Аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс болон үйл ажиллагааны бүсэд нэвтрэх хяналт .....	22
108.55(b)(5) Түр хугацаатай аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээ .....	22
Rule 108.55(b)(6) Тээш, ачаа, илгээмж, шуудан, агаарын хөлгийн хангамжийн эд зүйлсийн хамгаалалт.....	22
108.55(b)(7) Хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх- нислэгийн аюулгүй байдал .....	23
108.55(b)(8) Дамжих болон шилжин суух зорчигч, тэдгээрийн гар тээшний хяналт.....	25
108.55(b)(9) Дамжин суух зорчигч- гар тээшний хяналт .....	25
108.55(b)(10) Ачаа, түүнийг зөөвөрлөх хөдөлгөөний хамгаалалт .....	26

108.55(b)(11) Ачаа, эсхүл шуудангаас бусад илгээх барааны баглаа боодлын аюулгүйн үзлэг .....	27
108.55(b)(12) Зорчигч болон багийн гишүүдэд аюулгүйн үзлэг хийх .....	28
108.55(b)(13) Зорчигч, тээшний тулгалт .....	28
108.55(b)(14) Нислэг эхэлж буй агаарын хөлгийн нислэгийн өмнөх үзлэг .....	29
108.55(b)(15) Нисэх буудлын бүртгэлийн цэгээс өөр газраас эхлэлтэй тээш ..	29
108.55(b)(16) Тээшний аюулгүйн үзлэг .....	30
108.55(b)(17) Тээшний баталгаажуулалт .....	30
108.55(b)(18) Нислэгийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх.	30
108.55(c)(1) Зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас хүлээн авсан ачаа ба шуудан .....	31
108.55(c)(2) Бусад этгээдээс хүлээж авсан ачаа болон шуудан .....	31
108.55(d) Ачаа, шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналт .....	32
108.55(e) Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт багтсан ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналт .....	32
108.55(g) Олон улсын агаарын үйчилгээнд тээвэрлэхээр хүлээн авсан зорчигч болон тээш .....	32
108.55(h) Олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах тээш .....	33
108.55(i)(1) Дипломат шуудан .....	33
108.55(i)(2) Олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах ачаа ба шуудан .....	33
108.57 Нислэгт олгох аюулгүйн хамгаалалтын зөвшөөрөл .....	33
108.59 Ажилтны сургалт .....	34
108.60 Бүртгэл хөтлөх .....	35
108.61 Зөрчлийг мэдээлэх .....	36
108.63 Аюулгүйн үзлэг .....	36

Хавсралт I Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага, аэродром эзэмшигч болон агаарын тээвэрлэгч нарт зориулсан тээшинд үзлэг хийх Зөвлөмжийн мэдээлэл .....

1. Хүлээн зөвшөөрөхүйц аргачлал- Тээшний аюулгүйн үзлэг .....	37
2. Татгалзсан тээш .....	38
3. Аюулгүйн үзлэгийн бүс .....	38
4. Олон улсын нислэг рүү шилжүүлэх .....	38
5. Орон нутгийн нислэгээс олон улсын нислэг рүү шилжүүлэх .....	38
6. Дамжин өнгөрөх тээш .....	38
7. Овор ихтэй тээш .....	39
8. Илүүдэл тээш .....	39
9. Нислэгийн чиглэлийн өөрчлөлт .....	39
10. Эрт бүртгүүлсэн тээш .....	39
11. Буруу чиглэлд тээвэрлэгдсэн тээш/эзэнгүй цүнх .....	40

---

12.	Аюулгүйн үзлэг хийсэн болон хийгдээгүй тээшнүүд холилдсон .....	40
13.	Тээшний аюулгүйн хамгаалалтын зүүлт .....	40
14.	Бүлэг зорчигчийн тээшний бүртгэл .....	40
15.	Нисэх багийн тээш.....	40_Тос86241480
16.	Сэжигтэй тээш илэрсэн үед авах арга хэмжээ .....	40
17.	Аюултай бараа .....	40
18.	Давтан үзлэгийн тогтолцоо.....	40
19.	Үзлэгийн үед тээшинд дүрс хадгалах .....	41
20.	Чанар хяналтын явц.....	41

## **Энэхүү АС-д хэрэглэсэн тодорхойлолтууд**

Нийтлэг хэрэглэдэг тодорхойлолт нь ИНД-ийн нэр томъёоны тайлбар болон Иргэний нисэхийн тухай хуульд тусгагдсан болно.

Энэхүү АС-д ашигласан тодорхойлолт нь эдгээр хууль тогтоомж, эсхүл холбогдох тохиолдлоос үүсэлтэй бөгөөд, ерөнхий хэрэглэгч үйлдвэрлэгчийг тусгаж, нийтлэг ойлголтыг баталгаажуулах зорилгоор жагсаасан байна.

**Эзэнтэй тээш / Accompanied baggage** гэж зорчигч, эсхүл нисэх багийн гишүүдийн аялах агаарын хөлөгт бүртгүүлсэн тээшийг;

**Томилогдсон хүн / Appointed person** гэж тухайн нислэгийн тээшийг баталгаажуулах эрх бүхий агаарын тээвэрлэгч, эсхүл агаарын тээвэрлэгчийн агентаас томилогдсон этгээдийг;

**Баталгаажсан тээш / Authorised baggage** гэж тээшний баталгаажуулалтын шаардлага хангасан тээшийг;

**Тээш / Baggage** гэж үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу агаарын хөлөгт тээвэрлэж байгаа, эсхүл тээвэрлэхээр зорьж байгаа зорчигч, эсхүл багийн гишүүдийн хувийн өмч хөрөнгийг;

**Тээшний сав / Baggage container** гэж агаарын хөлөгт тээвэрлэх тээшийг ачих савыг;

**Тээш ялгах талбай / Baggage sorting area** гэж явах зорчигчийн тээшийг нислэгээр нь ялгах талбайг;

**Ачаа / Cargo** гэж шуудан, нөөц сэлбэг болон тээшнээс бусад, агаарын хөлөгт тээвэрлэж байгаа өмч хөрөнгийг;

**Гар тээш / Carry on baggage** гэж тээш болон дараах эд зүйлийг:

- (1) тухайн Үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу зорчигч, эсхүл багийн гишүүд агаарын хөлөгт авч ордог;
- (2) тухайн зорчигч, эсхүл багийн гишүүний хяналтад байдаг;

**Аюулгүй цүнх / Cleared Bag** гэж үзлэгийн бүх түвшинг хангасан аялахад аюулгүйн хамгаалалтын бүртгэгдсэн тээшний эд зүйлийг;

**Нисэх багийн тээш / Crew baggage** гэж агаарын хөлгийн нисэх багт харьяалагддаг тээшийг;

**Аюулгүйн хамгаалалтын мэдэгдэл / Declaration of Security** гэж ИНД-109-ийн шаардлагын дагуу ачаа, эсхүл шуудангаар илгээх барааны талаар үйлдсэн мэдүүлгийг;

**Шилжүүлэн ачих тээшинд зориулсан сав / Dedicated transfer baggage container** гэж нэг нисэх буудал руу хүргэгдэх шилжүүлэн ачих тээшинд зориулагдсан тээшний савыг;

**Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын хяналт болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын хяналтын арга хэмжээ / Enhanced Security Controls and Enhanced Security Control Measures** гэж дараах арга хэмжээний аль нэг болон түүнээс дээшийг:

- (1) гараар шалгасан;
- (2) нэг шалгагч нь хоёр өнцгөөр рентген төхөөрөмж ашиглан амжилттай үзсэн;
- (3) аюулгүйн хамгаалалтын шалгагчид үнэлүүлэх, шийдвэр гаргах зорилгоор дүрс өгөх заагч горим дээр ажиллаж буй гэрчилгээгүй тэсэрч дэлбэрэх бодисыг илрүүлэх системийг ашиглан үзсэн;
- (4) автомат, эсхүл заагч горим дээр ажиллах гэрчилгээжсэн тэсэрч дэлбэрэх бодисыг илрүүлэх системийг ашиглан үзсэн;
- (5) агаарын хөлөгт ачихаас өмнө нислэгийн тооцоот цагийн үлдсэн хугацаанд аюулгүй байдлыг хангасан; эсхүл
- (6) Даргын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын арга хэмжээ гэж баталгаажуулсан бусад арга хэмжээ.

**Түргэвчилсэн тээш / Expedite baggage** гэж агаарын тээвэрлэгч баталгаажуулсан, хайсан, эзнийг нь олж холбосон төөрсөн тээшийг;

**Хаалган дээр авах тээш / Gate baggage** гэж үндсэн тээшний манифест /бүртгэл/-эд нэмэгдээгүй агаарын хөлгийн ачааны хэсэгт байршуулах, эсхүл зорчигчоос нисэх буудлын зорчигч агаарын хөлөгт суулгах хаалган дээрээс авсан тээшийг;

**Тээшний манифест / Hold baggage manifest** гэж агаарын хөлгөөр тээвэрлэх бүх тээш, үүнд түргэвчилсэн тээш, нисэх багийн тээш, шилжүүлэн ачих тээш, хаалган дээр авах тээшийг гараар, эсхүл цахимаар, хосолсон хэлбэрээр бүртгэсэн бүртгэлийг;

**Бүртгэлтэй харилцагч / Known Customer** гэж илгээгчийн ачаа, эсхүл шууданг агаараар тээвэрлүүлэхээр Зохицуулалттай агаарын ачааны байгууллага, эсхүл агаарын тээвэрлэгчтэй холбоо тогтоосон, зохицуулалттай агаарын ачааны байгууллага, эсхүл Агаарын тээвэрлэгчид бүртгэлтэй ачаа, эсхүл шуудан илгээгчийг;

**Төөрсөн тээш / Mishandled baggage** гэж санаандгүй, эсхүл анхаарал болгоомжгүйгээр нисэх баг, эсхүл зорчигчоос төөрсөн тээшийг;

**Зохицуулалттай агаарын ачааны байгууллага / Regulated Air Cargo Agent** гэж ИНД-109-ийн дагуу олгосон, зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээ эзэмшигчийг;

**Аюулгүй байдлын мэдүүлэг / Security certificate** гэж Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг гэж түргэвчилсэн тээшийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын хяналтаар оруулж, агаарын хөлөгт тээвэрлэж болохыг бататгах зорилгоор өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын хяналтыг хийсэн этгээдийн бөглөсөн гэрчилгээг;

**Аюулгүйн хамгаалалтын хяналт / Security control** гэж хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодисыг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлж чадах арга хэмжээг;

**Сэжиглэх цүнх / Suspect Bag** гэж бүртгэсэн тээшинд нэг, эсхүл хоёр дугаар түвшингийн үзлэг хийхэд тэсэрч дэлбэрэх эд зүйлс байгааг заасан, цаашид шинжлэн шалгах эд зүйлсийг;

**Сэжигтэй цүнх / Suspicious Bag** гэж тээшийг үзлэг хийсний дараа аюулгүй болохыг нь тогтоож чадахгүй байгаа бөгөөд тэсэрч дэлбэрэх эд зүйлс байгаа үргэлжлүүлэн заасан цүнхийг;

**Шилжүүлэх тээш / Transfer baggage** гэж нэг агаарын хөлгөөс нөгөө агаарын хөлөг рүү шууд шилжүүлсэн тээшийг;

**Дамжин өнгөрөх тээш / Transit baggage** гэж -

- (1) аэродромд агаарын хөлөг ирэхэд түүний бүхээгт байсан;
- (2) тухайн аэродромыг агаарын хөлөг орхиход бүхээгт байсаар байгаа тээшийг;

**Зөвшөөрөгдөөгүй тээш / Unauthorised baggage** гэж тээшний баталгаажуулалтын шаардлага хангаагүй тээшийг;

**Тодорхойгүй тээш / Uncleared Bag** гэж агаарын хөлөгт тээвэрлэх зөвшөөрөл өгөх боломжгүй бүртгэсэн тээшин дэх эд зүйлд нэмэлт аюулгүйн үзлэг хийх тээшийг.



## **А Бүлэг – Ерөнхий зүйл**

### **108.1 Хамрах хүрээ**

9-өөс дээш зорчигчийн суудлын конфигурацитай (шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна) агаарын хөлгөөр тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээ эрхлэхээр ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн шугамын агаарын тээвэрлэгч болон 10, эсхүл түүнээс дээш зорчигч тээвэрлэх ИНД-129-ийн дагуу гэрчилгээжсэн гадаадын агаарын тээвэрлэгч нь ИНД-108-ийн шаардлагыг хангасан аюулгүйн хамгаалалтын хөтөлбөртэй байна.

ИНД-119, ИНД-129-ийн дагуу агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээвэрлэгчийн хөтөлбөртэй байх шаардлагыг Ерөнхий заавартаа тусгах ба аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт Даргын урьдчилсан зөвшөөрөлгүй нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.

## **В Бүлэг - Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлага**

### **108.51 Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр**

Энэ нь ерөнхий танилцуулах шаардлага агаарын тээврийн дотоодын болон олон улсын үйл ажиллагааг хамрах тусгай зохицуулалтын шаардлагад хүргэх юм.

#### **108.51(1) Гэрээний зохицуулалт**

Агаарын тээвэрлэгчийн үйлчилгээнд оролцох, гүйцэтгэх гэрээт, эсхүл бусад байгууллага нь уг агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг хангаж байгааг бататгах гэрээний нөхцөлийг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан байхыг энэ дүрмээр шаардана.

Гэрээт, эсхүл бусад байгууллагатай байгуулсан гэрээнд стандарт заалтын тодорхой агуулга хангалттай юм.

Зардал хуваах нислэгийн гэрээний зохицуулалтын хувьд аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт үүрэг, хариуцлагыг тодорхой тусгах шаардлагатай.

#### **108.51(2) Сургалт**

Энэ дүрэмд заасан аливаа сургалтыг гүйцэтгэх захирал, эсхүл түүний томилсон этгээдэд өөрийн чадамжийг харуулсан аюулгүйн хамгаалалтын багш-зааварлагч зохион байгуулах шаардлагатай. Агаарын тээвэрлэгч нь хүний нэр, эсхүл албан тушаалаар ангилж болно. Гэхдээ, сүүлчийн хандлагыг ашиглах бол хүмүүсийн чадамжийг тогтоох журмыг тодорхой болгох шаардлагатай. Батлагдсан хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хяналт шалгалтын үед баталгаажуулах, шалгах зорилгоор тээвэрлэгч хадгална.

**108.53 Аюулгүйн хамгаалалтын шаардлага- Орон нутаг**

Энэ дүрмийг ИНД-121 болон ИНД-125-ын дагуу орон нутгийн тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээ үзүүлэх бүх агаарын тээвэрлэгч мөрдөнө.

**108.53(b)(1) Агаарын хөлөгт галт зэвсэг тээвэрлэх**

Тогтмол агаарын тээврийн нислэг үйлддэг агаарын хөлгийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэх журам боловсруулахыг агаарын тээвэрлэгч байгууллагаас энэ дүрмийн дагуу шаарддаг.

Энэ дүрмийг мөрдөхийн тулд агаарын тээвэрлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт галт зэвсэг тээвэрлэх журмыг баримтжуулах шаардлагатай. Журам нь 91.9-д заасан галт зэвсэг тээвэрлэх журмын шаардлагыг хангасан байна:

- Даргын зөвшөөрөлгүй агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэхийг хориглоно;
- гүйцэтгэх захирлаас эрх шилжигдсэн агаарын тээвэрлэгчийн хариуцлагатай удирдах албан тушаалтан агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт галт зэвсэг авч явах тээвэрлэгчийн зөвшөөрлийг өгнө;
- агаарын хөлгийн даргад зорчигчийн бүхээгт галт зэвсэг авч явах зөвшөөрөлтэй хүний тоо, суудлын байрлалыг мэдэгдэх журам.

Тогтмол агаарын тээврийн нислэг үйлддэг агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэх зөвшөөрлийг зөвхөн дараах тохиолдолд олгоно:

- (a) зохих ёсоор эрх олгогдсон цагдаа, эсхүл хууль сахиулах байгууллагын ажилтан;
- (b) Дарга галт зэвсэг авч явахыг чухал гэж үзсэн бол;
- (c) цагдаагийн дарга зөвшөөрөл олгохыг хүссэн хүсэлтийг дэмжсэн бол;
- (d) агаарын тээвэрлэгч авч явахыг зөвшөөрсөн бол.

**108.53 (b)(2) Заналхийллийн эсрэг авах хариу арга хэмжээний журам**

Энэ дүрмээр агаарын хөлгийг булаах, тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, эсхүл бусад хууль бус үйлдлийн заналхийлэл бий болсон үед агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүд болон газрын ажилтанд учрах аюулыг багасгах зорилгоор агаарын тээвэрлэгчийн удирдлага, багийн гишүүд, газрын ажилтны хэрэгжүүлэх онцгой нөхцөлийн журмыг баримтжуулсан байхыг шаардана.

Дээрх нөхцөл байдал үүссэн үед мөрдөх онцгой нөхцөлийн журамд дараах зүйлийг тусгана:

- (a) анхан шатны мэдэгдэл;
- (b) сонордуулах мэдээлэл;
- (c) нисэх бүрэлдэхүүн болон газрын ажилтны үйл ажиллагаа;
- (d) агаарын тээвэрлэгчийн удирдлагын үйл ажиллагаа;
- (e) бусад байгууллагатай хамтран ажиллах хамтын ажиллагаа;

(f) хэвлэл мэдээлэл.

Агаарын тээвэрлэгч нь тэсрэх бөмбөгөөр заналхийлэх үед хэрэгжүүлэх онцгой нөхцөлийн журмыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан байх шаардлагатай. Энэ талаарх нарийвчилсан мэдээлэл нь аюулгүйн хамгаалалтын хувьд мэдрэмтгий тул олон нийтэд нээлттэйгээр АС-д тусгаж нийтийн хүртээл болгоход тохиромжгүй юм. Холбогдох мэдээллийг дараах хаягаар авна уу:

Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтэс

Иргэний нисэхийн ерөнхий газар

Буянт-Ухаа 17120

Э-шуудан: [AGA@mcaa.gov.mn](mailto:AGA@mcaa.gov.mn)

### **108.53 (b)(3) Үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн аюулгүй байдал**

Энэ дүрмээр үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийг хууль бус үйлдлээс сэргийлэх зорилгоор аюулгүй байдлыг нь хангах журам боловсруулахыг шаардсан.

Үйлчилгээнд гараагүй агаарын хөлөгт нисэх багийн гишүүн, агаарын тээвэрлэгчийн газрын ажилтан, эсхүл төлөөлөгч байхгүй үед агаарын хөлөгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх хангалттай журам хэрэгтэй ба нэвтэрсэн тохиолдолд агаарын хөлөгт 108.53 (b)(8)-ын дагуу аюулгүйн үзлэг хийгдэнэ. Эдгээр журмын зорилго нь агаарын хөлгийг тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээнд ашиглахын өмнө агаарын хөлгийн аюулгүй байдлыг бүхэлд нь хадгалахад оршино.

Журам, хариуцлагын баримт бичгийг баримтжуулж, агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт оруулах ба тогтмол хэрэгжүүлдэг байх шаардлагатай.

Үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтын журамд дараах зүйлийг тусгана:

(a) агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа:

- (1) тусгай нислэгт бэлтгэх;
- (2) транзит нислэг, түүнтэй адилхан нөхцөлд бэлтгэх;
- (3) шөнийн зогсоолд тавьсан, эсхүл үйлчилгээнээс түр зуур гарах;

(b) агаарын хөлгийн хаалга, аваарын хаалга, тээш, ачааны хэсгийн хаалганы аюулгүй байдлыг хангах зорилгоор хаасан байх;

(c) агаарын хөлөгт нэвтрэх хэрэгсэл болох шатыг холдуулах, эсхүл агаарын хөлгийг нисэх буудлын хоолойноос салгаж байрлуулах;

(d) дараах аэродромд шөнө зогсоолд тавьсан агаарын хөлгийг гэрэлтүүлгээр хангах, эсхүл бусад хамгаалалт тогтоох. Холбогдох арга хэмжээг авна:

- (1) шөнийн турш аюулгүйн хамгаалалтын хяналтад байх аэродром;
- (2) шөнийн турш бус аюулгүй байдал хангах аэродром.

(е) үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийг байрлуулсан ангарын аюулгүй байдлыг хангах;

(f) нисэх бүрэлдэхүүн болон бусад эрх бүхий хүмүүс үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн дотоод болон гадаад үзлэг шалгалтыг дараах нөхцөлд хийнэ:

- (1) энгийн нөхцөлд;
- (2) 108.53(b)(8)-ын дагуу агаарын хөлөг эхний нислэгээ хийх, эсхүл техник үйлчилгээнээс буцаж ирж байгаа үед агаарын хөлөгт үзлэг хийх нөхцөлд;
- (3) агаарын хөлөгт зөвшөөрөлгүй нэвтэрсэн, эсхүл сэжиглэх үндэс бий болсон тохиолдолд;
- (4) агаарын хөлөг энгийн заналхийллийн хүчин зүйлээс өндөр нөхцөлд;
- (5) агаарын хөлөг хууль бус үйлдэлд өртсөн, эсхүл сэжиглэх үндэс бий болсон тохиолдолд.

(g) агаарын хөлөгт нэвтрэх зөвшөөрөлтэй хүмүүс (нэвтрэх үнэмлэх, зорчигчийн суугчийн талон, газрын үйлчилгээний байгууллагын ажилтан, нисэх бүрэлдэхүүн) болон агаарын тээвэрлэгчийн нисэх бүрэлдэхүүн, газрын үйлчилгээний байгууллагын ажилтан нарын үнэмлэхийг шалгах.

**108.53(b)(4) Аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн хамгаалалттай бүс болон бусад үйл ажиллагааны бүсэд нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих**

Агаарын тээвэрлэгч нь тухайн байгууллагын эзэмшилд, эсхүл түрээслэн ашиглаж байгаа байгууламжид нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих журмыг боловсруулсан байна. Эдгээр журамд агаарын тээвэрлэгчийн зорчигч, ажилтан, ачаа, тээш, агаарын хөлгийн хангамжийн хэрэгслийг нэвтрүүлэхэд зөвхөн тухайн цаг хугацаа, нөхцөлд ашиглана. Агаарын тээвэрлэгч нь эдгээр журмыг өөрийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгана.

Агаарын тээвэрлэгч нь дээр дурдсан байгууламжид зөвшөөрөлгүй этгээд нэвтэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх дэс дараатай авч хэрэгжүүлэх арга хэмжээг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгана:

(a) дээрх байгууламжид зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй бол; эсхүл

(b) нэвтрэх үйл ажиллагаанд тавих хяналтыг ямар нэгэн шалгаанаар аливаа этгээд зөрчсөн тохиолдолд сэжигтэй гэж үзэж саатуулах талаар.

Агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдал болон аюулгүй ажиллагааны эрсдэлийг бууруулах, тухайлбал агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтын шалгалт хийх нарийвчилсан арга хэмжээ шаардлагатай юм.

**108.53(b)(5) Тээш, ачаа, илгээмж, шуудан, агаарын хөлгийн хангалт, нөөцийн хамгаалалт**

Энэ дүрмээр агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт тээвэрлэх тээш, ачаа, илгээмж, шуудан, агаарын хөлгийн хангалт, нөөц болон агаарын хөлгийн

хангалтад зохих аюулгүйн хамгаалалтын хяналт тавих журмыг боловсруулахыг шаардана.

### **Тээш**

Агаарын тээвэрлэгчийн зорчигчийн тээшийг хүлээж авснаас хойш тээш байгаа газарт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх журмыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөртөө тусгасан байна. Агаарын тээвэрлэгчийн хамгаалалтад авсан тээшийг аюулгүй газар байлгана.

### **Ачаа ба илгээмж**

Зорчигч тээврийн агаарын хөлгөөр тээвэрлэх ачаа, илгээмжинд хууль бус үйлдэлд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис болон бусад аюултай хэрэгсэл, эд зүйл нэвтрүүлэхээс сэргийлэх журмыг энэ дүрмийн дагуу боловсруулсан байна.

ИНД-109 “Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт” нь зөвхөн олон улсын зорчигч тээврийн үйлчилгээний агаарын хөлгөөр тээвэрлэх ачаатай холбоотой болно.

Агаарын хөлөгт хууль бус үйлдэлд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл нэвтрүүлэхээс сэргийлэх аюулгүйн хамгаалалтын арга хэмжээ аваагүй ачаа тээвэрлэх бол зөвхөн тодорхой харилцагчаас хүлээж авна.

Агаарын тээвэрлэгчийн хөтөлбөрт ачаа тээвэр зуучийн байгууллагыг тодорхой харилцагч гэж хүлээн зөвшөөрөх арга хэрэгсэл болон ачаа тээвэрлүүлэхээр ачаа хүлээн авах хүмүүс эдгээр тодорхой харилцагч нарыг мэдэх хэрэгслийг тусгасан байх шаардлагатай:

- (a) ачаа тээвэр зуучийн байгууллагыг тодорхой бус гэдгийг тогтоох;
- (b) дээрх тодорхой харилцагчийн журамд нийцсэн гэдгийг баталгаажуулж чадаагүй;
- (c) хүргэлтийг гуравдагч этгээдээр дамжуулсан;
- (d) ачаа тээвэр зуучийн байгууллагын үйлдэл сэжигтэй байсан-

ачаанд байгаа эд зүйлийг гараар тодорхойлох, эсхүл рентген төхөөрөмжөөр шалгасан байх.

### **Шуудан**

Агаарын хөлгөөр тээвэрлэх шууданг энгийн шуудангийн сувгаас хүлээж аваагүй агаарын шуудан болон агаарын илгээмжийг хамгаалах журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Шуудангийн лацыг шалгах, эсхүл бусад аюулгүйн хамгаалалтын арга хэмжээг шуудангийн байгууллага болон бусад оролцогч байгууллагатай тохиролцож шууданг хөндлөнгийн халдлагаас хамгаална.

**Агаарын хөлгийн хангалт, нөөц болон агаарын тээвэрлэгчийн хангалтын эд зүйл**

Агаарын хөлгийн хангалт, нөөцтэй (агаарын тээвэрлэгчийн үзүүлэх нислэгийн хоол хүнсний хангамжийн эд зүйлийг багтаасан) холбоотой аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг баримтжуулсан байна.

Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлгийн хангалт, нөөцийг аюулгүй орчинд тодорхой, эсхүл итгэлтэй харилцагч бэлтгэж байгааг баталгаажуулсан журамтай байх шаардлагатай. Нийлүүлэгч нь тодорхой харилцагч, эсхүл итгэлтэй харилцагч болохыг тогтоох аргачлалыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан байна. Агаарын хөлгийн хангалт, нөөцийг аэродромын аюулгүй бүсээс өөр газар бэлтгэсэн тохиолдолд хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл аюултай хэрэгсэл, эд зүйл байхгүй болохыг бататгах журмыг боловсруулсан байна.

#### **108.53(b)(6) Хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх- нислэгийн аюулгүй байдал**

Агаарын тээвэрлэгч нь хууль, хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэхдээ нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах журам боловсруулсан байна. **Энэ журамд мөн 108.53(с)-ийн шаардлагыг тусгасан байна.**

Арилжааны нислэгээр хууль, хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх тохиолдолд 108.58-ийн дагуу Монгол Улсын болон гадаадын төрийн байгууллага нь агаарын тээвэрлэгчид мэдэгдсэн байх шаардлагатай. Агентлаг нь санал болгосон аяллын нөхцөл байдлыг агаарын тээвэрлэгчид мэдэгдэх ёстой. Агаарын тээвэрлэгч зөвшөөрсөн тохиолдолд агаарын хөлгийн даргад мэдэгдэнэ. Оролцогч агентлаг нь тухайн агаарын тээвэрлэгчийн тогтоосон бүх нөхцөлийг дагаж мөрдөх ёстой.

Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт 108.53(b)(6)-д нийцсэн дараах шаардлагыг тусгасан байна:

(а) нислэг болон бусад зорчигч, нисэх бүрэлдэхүүнийг хамгаалах, эрсдэлийг багасгах;

(b) аюулгүй ажиллагаанд харшилна гэж агаарын тээвэрлэгч үзсэн тохиолдолд хууль, цагдаагийн байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэхээс татгалзах;

(c) тухайн этгээдийг нэг агаарын тээвэрлэгчийн нислэгээс өөр агаарын тээвэрлэгчийн нислэгт шилжүүлэн суулгах бол нислэг эхлэхээс өмнө холбогдох байгууллагад мэдэгдэх;

(d) хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх тохиолдолд 108.53(с)-ийн дагуу дараах шаардлагыг биелүүлсэн байх:

- (1) хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг зорчигч тээврийн нислэгээр тээвэрлэх тохиолдолд нэг хүнд нэг, эсхүл түүнээс дээш тооны харгалзчтай тээвэрлэх;
- (2) зэвсэг болгон ашиглаж болох эд зүйл авч яваагүй болохыг харгалзагч шалгаж бататгасан байх;

- (3) харгалзагч нь тухайн этгээдийн үйлдлийг хязгаарлах тохирох хэрэгсэлтэй байх. Хөдөлгөөнийг хязгаарлах хэрэгслээр хоригдлыг агаарын хөлгийн аль ч хэсэгт гинжлэхгүй байх;
  - (4) харгалзагч, хүчний байгууллагын ажилтан нь нислэг үйлдэх болон аяллын туршид шилжин, дамжин суух цэгийн аюулгүйн хамгаалалтын ажилтан, ажил үүргээ гүйцэтгэж байгаа хууль хяналтын байгууллагын ажилтанд танигдахуйц байх;
  - (5) агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн дарга болон ахлах үйлчлэгч хоригдол, эсхүл хоригдлууд, түүний харгалзагчийн талаар мэдсэн байх ба аюулгүйн хамгаалалтын урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, суудлын хуувирлалтыг хийх;
  - (6) хууль, хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг бусад зорчигчоос өмнө агаарын хөлөгт суулгаж, бусад зорчигч бүгд буусны дараа агаарын хөлгөөс гаргах;
  - (7) хууль, хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээд, түүний харгалзагчийг агаарын хөлгийн арын суудалд гарах хаалганаас хол суулгах;
  - (8) агаарын хөлгийн суудлын зохион байгуулалтаас хамаарч хууль, цагдаагийн хяналтад байгаа этгээд, түүний харгалзагчийг суулгах ба хоёр этгээд авч яваа тохиолдолд харгалзагчийг дунд нь суулгана. Боломжгүй тохиолдолд харгалзагчийг тухайн этгээдийн өөдөөс харуулж суулгах;
  - (9) харгалзагч хууль, цагдаагийн хяналтад байгаа этгээдийг байнга дагах;
  - (10) хууль, цагдаагийн хяналтад байгаа этгээд, түүний харгалзагчид согтууруулах ундаа, металл хэрэгслээр үйлчлэхгүй байх;
  - (11) агаарын тээвэрлэгч болон хамгаалалтын агентлагаас тухайн этгээдийг аюултай гэж үзсэн тохиолдолд 2-оос доошгүй харгалзагчаар хангах. Нэг нислэгээр хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа нэг этгээд, түүний харгалзагчийг зөөвөрлөх;
  - (12) ямарч нөхцөлд, агаарын тээвэрлэгч нь 108.53(с)(9)-ийн дагуу нэг нислэгээр зөөвөрлөх хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийн тоонд хязгаарлалт тогтооно:
    - 29-өөс дээш суудалтай агаарын хөлөгт хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа нэг этгээд;
    - нэмэлт 25 суудал бүрд хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа нэг этгээдийг нэмэх (Доорх Хүснэгт 1-ийг харарх);
- (e) агаарын тээвэрлэгч оюун санааны хомсдолтой этгээд тээвэрлэх нь аюултай гэж үзсэн тохиолдолд дараах арга хэмжээг авна:
- шаардлагатай үед тухайн хүмүүсийн үйлдлийг зогсоож чадах бие бялдрын хөгжилтэй хүн дагаж явах;
  - тухайн этгээдийг дагалдан яваа хүнд шаардлагатай эм тариа байгааг шалгах;

- нисэн гарахаас өмнө номхруулах эм, тариа хэрэглэдэг бол нислэгийн хугацаа нь тухайн эм, тарианы үйлчилгээ дуусахаас бага байх шаардлагатай тул үүнийг судалж тухайн этгээдийг тээвэрлэх.

(f) Монгол Улсаас албадан гаргаж байгаа болон хууль зөрчсөн гадаадын иргэдийг агаарын хөлгөөр тээвэрлэн гаргахад нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх эсэхийг үнэлж дүгнэсэн байх шаардлагатай. Энэхүү үнэлгээг агаарын тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэх ба аюулгүй байдалд эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд агаарын тээвэрлэгчийн нисэхийн аюулгүйн хамгаалалтын мэргэжилтэнтэй зөвшилцөж шийднэ. Үүнийг үндэслэж аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээ авах эсэхийг агаарын тээвэрлэгч тогтооно.

Дараах Хүснэгт нь 108.53(c)(9) and 108.55(c)(9)-ийн дагуу зөөвөрлөх хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийн хамгийн их тоог тусгасан байна.

Хүснэгт 1 - Агаарын хөлөг суудлын багтаамжинд тохирсон хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийн хамгийн их тоо

Агаарын хөлгийн зөвшөөрөгдсөн суудлын багтаамж	Зөөвөрлөх хууль хяналтын байгууллагын хяналтад этгээдийн хамгийн их тоо
1-29	1
30-54	2
55-79	3
80-104	4
105-129	5
130-154	6
155-179	7
180-204	8
205-229	9

### **108.53(b)(7) Зорчигч, тээшний тулгалт- агаарын хөлөгт суугаагүй зорчигч**

Энэ шаардлага нь зорчигчийн бүртгэгдсэн тээшинд тавих аюулгүйн хамгаалалтын бусад арга хэмжээ дээр нэмэлт болно. Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт зөвхөн тулгасан тээшийг агаарын хөлөгт ачих журмыг боловсруулж, тусгасан байна. Тулгалт нь зөөвөрлөх тээш, зорчигчийн хооронд хийгдэнэ. Энэ шаардлагын зорилго нь тогтмол нислэгээр зорчих бүх бүртгүүлсэн хүмүүс (дамжин, шилжин суух зорчигч) агаарын хөлөгт суух, эсхүл дахин суусныг баталгаажуулахад оршино. Зорчигч агаарын хөлөгт суугаагүй, эсхүл дахин суугаагүй бол түүний тээшийг ачихгүй, эсхүл агаарын хөлөгт түүний тээшийг ачсан тохиолдолд агаарын тээвэрлэгч болон агаарын хөлгийн дарга нь аюулгүйн хамгаалалтын эрсдэлд үнэлгээ хийнэ.

Агаарын хөлгийн даргын эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан тээшийг тээвэрлэх, эсхүл агаарын хөлөг хөөрөхөөс өмнө буулгах асуудлыг шийдвэрлэнэ. Агаарын хөлөгт суугаагүй этгээдийн бүртгүүлсэн тээшийг тогтмол нислэгийн агаарын хөлөгт холбогдох сургалтад хамрагдсан, мэдлэг чадвартай аюулгүйн



хамгаалалтын ажилтан тусгай үзлэг шалгалт хийхээс өмнө дахин ачихыг хориглоно. Аюулгүйн үзлэг шалгалтад рентген төхөөрөмж ашиглахаас гадна түүнийг гараар шалгасан байна.

Агаарын тээвэрлэгч нь зорчигчоос үл хамаарах дараах нөхцөл байдлын улмаас зорчигч агаарын хөлөгт нэвтэрч, эсхүл дахин сууж чадаагүй тохиолдолд тээшийг үлдээх журмыг боловсруулсан байна:

- (a) зорчигч бүртгүүлсний дараа агаарын хөлөг нисэн гарахаас өмнө нас барсан;
- (b) үйл ажиллагааны хүчин зүйл болох цаг агаар, эсхүл техникийн шалтгааны улмаас нислэг хойшлогдох, цуцлагдах, эсхүл анх төлөвлөсөн нислэгээр хүрэх аэродромын үйл ажиллагааны нөхцөл зэргээс хамаарч зорчигч өөрөө өөр нисэх буудал дээр буух шийдвэр гаргасан;
- (c) агаарын тээвэрлэгч нь жин, эсхүл ижил төрлийн үйл ажиллагааны шаардлагын улмаас тээш, эсхүл зорчигчийн маршрутыг дахин тогтоохдоо зорчигчийг хүлээлгүй тээшний бүртгэлийг хийнэ. Энэ нь зорчигч сайн дураараа тээшээ буулгах эсхүл зорчигчийн хүсэлтээр өөрчлөлт орсон тохиолдолд хамаарахгүй.

Дээрх журамтай холбоотой шийдвэр гаргах үйл явцыг баримтжуулах ба үүнд нисэн гарах агаарын хөлгийн даргатай зөвшилцсөн байх асуудал мөн багтсан байна.

#### **108.53(b)(8) Зорчигчийн аюулгүйн үзлэгийн үед үүссэн онцгой байдал**

Орон нутгийн нислэгт аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэн тохиолдолд агаарын тээвэрлэгчийн онцгой нөхцөлийн журам болон Иргэний нисэхийн тухай хуулийн 40.1-д заасан шаардлага, 108.63-ын дагуу зорчигч, нисэх баг, тэдгээрийн гар тээшинд аюулгүйн үзлэг хийх асуудлыг агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан байна.

108.63-ын дагуу аюулгүйн үзлэгийг Монгол Улсад Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага, эсхүл тус байгууллагын шууд хяналтад холбогдох албан тушаалтан гүйцэтгэнэ.

Энэ нь агаарын хөлөгт хориглосон эд зүйлс, аюултай ачаа авч орохоос урьдчилан сэргийлэхэд хангалттай хэмжээнд зохион байгуулагдсан байна. Аюулгүйн үзлэг хийлгэсэн этгээд аюулгүйн хамгаалалтын хяналтаар ороогүй хүнтэй уулзах болон эд хэрэгсэл авах боломжгүй газарт аюулгүйн үзлэгийг хийнэ.

Зорчигч аюулгүйн үзлэгт хамрагдсаны дараа аюулгүйн хамгаалалтын хяналтаар ороогүй хүнтэй уулзсан, эд хэрэгсэл авсан тохиолдолд агаарын хөлөгт нэвтэрсэн болон хүлээлгийн танхимд байгаа хүмүүс дахин аюулгүйн үзлэгт хамрагдана. Энэхүү шаардлага хувь хүний хувьд аюулгүйн үзлэг дууссанаас хойш агаарын хөлөг хөөрөхөөр хаалгаа хаах хүртэл тавигдана. Өөрийн биед, эсхүл гар тээшиндээ аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан этгээд, эсхүл түүний гар тээшийг агаарын тээвэрлэгч агаарын хөлөгт оруулахаас болон аюулгүйн үзлэгт хамрагдсан хүнтэй уулзахыг хориглож хяналт тавьж ажиллана.

Ажлын айлчлал хийж буй Хаан болон улсын тэргүүн, тэдгээрийн гэр бүлийн хүнийг зорчигчийн аюулгүйн үзлэгээс чөлөөлнө. Тухайн этгээд холбогдох хамгаалалттай нөхцөлд энэ шаардлага үйлчлэх ба албан ёсны хамгаалалтын тал нь тэдгээрийн тээшний аюулгүй байдлыг хариуцна. Энэ чөлөөлөх шаардлага нь Хаан, эсхүл улсын тэргүүнтэй хамт аялж байгаа бусад хүмүүст үйлчлэхгүй болно.

#### **108.53(b)(9) Орон нутгийн нислэгийн тээшний үзлэгийн үед үүссэн онцгой байдал**

Орон нутгийн нислэгт аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэн тохиолдолд агаарын тээвэрлэгчийн онцгой нөхцөлийн журам болон Иргэний нисэхийн тухай хуулийн 40.1-д заасан шаардлага, 108.63-ын дагуу зорчигч, нисэх багийн гар тээшнээс бусад эд зүйлд аюулгүйн үзлэг хийх шаардлагыг агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан байна.

108.63-ын дагуу аюулгүйн үзлэгийг Монгол Улсад Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага, эсхүл тус байгууллагын шууд хяналтад холбогдох албан тушаалтан гүйцэтгэнэ.

Тээшинд аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан тохиолдолд тухайн тээшийг агаарын хөлөгт оруулахыг хориглоно.

Аюулгүйн үзлэгийг зөвшөөрөлгүй, эсхүл аюулгүйн үзлэг хийлгээгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлсэн орчинд гүйцэтгэнэ.

Ажлын айлчлал хийж буй Хаан болон улсын тэргүүн, тэдгээрийн гэр бүлийн хүний тээшийг аюулгүйн үзлэгээс чөлөөлнө. Тухайн этгээд холбогдох хамгаалалттай нөхцөлд энэ шаардлага үйлчлэх ба албан ёсны хамгаалалтын тал нь тэдгээрийн тээшний аюулгүй байдлыг хариуцна. Энэхүү чөлөөлөх шаардлага нь Хаан, эсхүл улсын тэргүүнтэй хамт аялж байгаа бусад хүмүүст үйлчлэхгүй болно.

#### **108.53(b)(10) Аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэн**

Захирал аюулгүйн хамгаалалтын түвшин нэмэгдсэн үед агаарын тээвэрлэгчээс нэмэлт аюулгүйн хамгаалалтын арга хэмжээ авахыг шаардсан үед хэрэгжүүлэх журам, зааврыг боловсруулсан байхыг агаарын тээвэрлэгчээс шаардана. Агаарын тээвэрлэгч нь Захирлын онцлон заасан аэродромоос нислэг үйлдэхдээ хэрэгжүүлэх тусгай журмыг боловсруулсан байна.

#### **108.53(b)(11) Агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэх**

Энэ дүрэм нь агаарын тээвэрлэгчээс агаарын хөлгийн маяг, тохиргоотой холбогдуулан нисгэгчийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх журмыг боловсруулна. Эдгээр журмыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр, эсхүл агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагын дагуу үйл ажиллагааны зааварт байрлалыг нь заасан байна.

Нисэх багийн бүхээгийн хаалгатай агаарын хөлөгт нислэгийн хугацаанд хаалга онгорхой үед зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглох аргачлалыг тусгасан журмаар хангана.

Зааварчилгааны дагуу нисэх багийн бүхээгээс гарах этгээд нь хаалга онгойлгохоос өмнө дараах арга хэмжээг авна:

- ариун цэврийн хэсгийн ойролцоо зорчигч байгаа эсэхийг бүхээгийн ажилтнаар шалгуулсан байх;
- хаалганы гадна талын нөхцөл байдлыг тодорхойлох ялангуяа өндөр эрсдэлтэй нислэг, эсхүл танихгүй зорчигч хаалгаар амархан орох;
- хаалга нээлттэй үед бүхээгийн ажилтан хаалганы хэсэг рүү зорчигчийг нэвтрүүлэхгүй байхаар хааж зогсох.

Нисэх багийн бүхэгт орж, гарахдаа хаалгыг нээхэд зориулж маш бага хугацаа зарцуулах нь үндсэн суурь болно.

Агаарын хөлөг нисэх багийн бүхээгийн хаалгагүй тохиолдолд нисэх багийн бүхээгт нэвтрэх журам, арга хэрэгслийг тогтоосон байна. Үүнд холбогдох дохио, зорчигчдод урьдчилан мэдэгдэх, эсхүл агаарын хөлгийн маягаас хамаарсан бусад журмын аргачлал багтана.

Агаарын хөлгийн нисэх багийн бүхээг хаалттай байхаас үл хамааран нисэх багийн бүхээгт агаарын хөлгийн даргын зөвшөөрөлтэй хүн нэвтрэх ба холбогдох журмыг боловсруулсан байна. Зөвхөн агаарын хөлгийн даргын зөвшөөрсөн хүмүүсийг нэвтрэхийг зөвшөөрнө. Нисэх багийн бүхээгт нэвтрэх журмыг боловсруулж, хүний тоо бага байна.

### **108.55 Аюулгүйн хамгаалалтын шаардлага - Олон улс**

ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгч нь 9-өөс дээш зорчигчийн суудлын конфигурацитай агаарын хөлгийг олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний нислэгт ашиглах бол энэ дүрмийг мөрдөнө. ИНД-129-ийн дагуу гэрчилгээжсэн бүх гадаадын агаарын тээвэрлэгч нь гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаанд 10, эсхүл түүнээс дээш зорчигч тээвэрлэх бол мөн энэ дүрмийг мөрдөнө.

#### **108.55(b)(1) Агаарын хөлөгт галт зэвсэг тээвэрлэх**

Агаарын тээвэрлэгч нь агаарын тээврийн тогтмол нислэгт ашиглаж буй агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэх журам боловсруулахыг энэ дүрмээр шаардана. Монгол Улсад болон Монгол Улсаас, эсхүл гадаад улсын аэродромоос Монгол Улсын аэродромд нисэн ирэх агаарын тээвэрлэгч нь галт зэвсэг тээвэрлэх журамтай байна. Журамд 91.9-д заасан галт зэвсэг тээвэрлэхтэй холбоотой дараах шаардлагыг тусгасан байна:

- Даргын зөвшөөрөлгүй агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэхийг хориглох;
- агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэх зөвшөөрөл олгох агаарын тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл;

- агаарын хөлгийн бүхээгт галт зэвсэг авч явахыг зөвшөөрсөн хүмүүсийн тоо болон суудлын дугаарыг агаарын хөлгийн даргад мэдэгдэх журам.

Дарга зөвхөн дараах тохиолдолд агаарын тээврийн тогтмол нислэгт ашиглаж байгаа агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт галт зэвсэг авч явах зөвшөөрөл олгоно:

- (a) цагдаагийн байгууллага, бусад хүчний байгууллагын зөвшөөрөлтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан;
- (b) Даргаас галт зэвсэг авч явахыг зайлшгүй гэж үзсэн;
- (c) цагдаагийн байгууллагаас зөвшөөрлийг дэмжсэн;
- (d) агаарын тээвэрлэгч галт зэвсэг тээвэрлэхийг зөвшөөрсөн.

### **108.55(b)(2) Заналхийллийн эсрэг авах хариу арга хэмжээний журам**

Энэ дүрмээр агаарын хөлгийг булаах, тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, эсхүл хууль бус үйлдлийн бусад заналхийлэл бий болсон үед агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүд болон газрын ажилтанд учрах аюулыг багасгах зорилгоор агаарын тээвэрлэгчийн удирдлага, багийн гишүүн, газрын ажилтны хэрэгжүүлэх онцгой нөхцөлийн журмыг баримтжуулсан байхыг шаардана.

Дээрх нөхцөл бий болсон үед мөрдөх онцгой нөхцөлийн журамд дараах зүйлийг тусгана:

- (a) анхан шатны мэдэгдэл;
- (b) сонордуулах мэдээлэл;
- (c) нисэх бүрэлдэхүүн болон газрын ажилтны үйл ажиллагаа;
- (d) агаарын тээвэрлэгчийн удирдлагын үйл ажиллагаа;
- (e) бусад байгууллагатай хамтран ажиллах хамтын ажиллагаа;
- (f) хэвлэл мэдээлэл.

Агаарын тээвэрлэгч нь тэсрэх бөмбөгөөр заналхийллийн үнэлгээний дагуу тэсрэх бөмбөгөөр заналхийлэх үед ажиллах онцгой нөхцөлийн журмыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан байх шаардлагатай. Энэ талаарх нарийвчилсан мэдээлэл нь аюулгүйн хамгаалалтын хувьд мэдрэмтгий тул олон нийтэд нээлттэй АС-д тусгаж нийтийн хүртээл болгоход тохиромжтой биш юм. Холбогдох мэдээллийг дараах хаягаар авна уу:

Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтэс

Иргэний нисэхийн ерөнхий газар

Буянт-Ухаа 17120

Э-шуудан: [aga@mcaa.gov.mn](mailto:aga@mcaa.gov.mn)

**108.55(b)(3) Үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалт**

Энэ дүрэм үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийг хууль бус үйлдлээс сэргийлэх зорилгоор аюулгүй байдлыг нь хангах журам боловсруулахыг агаарын тээвэрлэгчээс шаардсан.

Үйлчилгээнд гараагүй агаарын хөлөгт нисэх багийн гишүүн, агаарын тээвэрлэгчийн газрын ажилтан, эсхүл төлөөлөгч байхгүй үед агаарын хөлөгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх хангалттай аюулгүйн хамгаалалтын журам хэрэгтэй. Эдгээр журмын зорилго нь агаарын хөлгийг тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээнд ашиглахын өмнө агаарын хөлгийн аюулгүй байдлыг бүхэлд нь хадгалахад чиглэгдэнэ. Боловсруулсан журам, албан тушаалтны үүрэг, хариуцлагыг агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгаж, байнга мөрдөж ажиллана.

Үйлчилгээнд гаргаагүй агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтын журамд дараах зүйлийг тусгана:

- (a) агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа:
  - (1) тодорхой нислэгт бэлтгэх;
  - (2) транзит нислэг үйлдэхэд бэлтгэх;
  - (3) шөнийн зогсоолд тавьсан, эсхүл үйлчилгээнээс түр зуур гаргах;
- (b) агаарын хөлгийн хаалга, аваарын хаалга, тээш, ачааны хэсгийн хаалганы аюулгүй байдлыг хангах зорилгоор хаасан байх;
- (c) агаарын хөлөгт нэвтрэх хэрэгсэл болох шатыг холдуулах, эсхүл агаарын хөлгийг нисэх буудлын хоолойноос салгаж байрлуулах;
- (d) шөнө зогсоолд тавьсан агаарын хөлгийг гэрэлтүүлгээр, эсхүл бусад хамгаалалтаар хангах. Дараах нөхцөлд тохирсон өөр өөр арга хэмжээ авах:
  - (1) бүхэл шөнийн турш аюулгүйн хамгаалалтын хамгаалалттай аэродром;
  - (2) бүхэл шөний турш аюулгүйн хамгаалалтын хамгаалалтгүй аэродром;
- (e) үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийг байрлуулсан ангарын аюулгүй байдлыг хангах;
- (f) нисэх бүрэлдэхүүн болон бусад эрх бүхий хүмүүс үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн дотоод болон гадаад үзлэг шалгалтыг хийх нөхцөл—
  - (1) энгийн нөхцөл;
  - (2) агаарын хөлөгт зөвшөөрөлгүй нэвтэрсэн, эсхүл сэжиглэл бий болсон нөхцөл;
  - (3) агаарын хөлгийг энгийн заналхийллийн хүчин зүйлээс өндөр үед ашигласан нөхцөл;
  - (4) агаарын хөлөгт хөндлөнгөөс халдсан нөхцөл;
- (g) агаарын хөлөгт нэвтрэх зөвшөөрөлтэй хүмүүс (нэвтрэх үнэмлэх, зорчигчийн суугчийн талон, газрын үйлчилгээний байгууллагын ажилтан, нисэх бүрэлдэхүүн) болон агаарын тээвэрлэгчийн нисэх бүрэлдэхүүн, газрын үйлчилгээний байгууллагын ажилтан нарын үнэмлэхийг шалгах.

**108.55(b)(4) Аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс болон үйл ажиллагааны бүсэд нэвтрэх хяналт**

Агаарын тээвэрлэгч нь түрээсэлсэн, өөрийн эзмшиж буй, эсхүл тээвэрлэгч, агентын ашиглаж байгаа байгууламжаар дамжин нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих журам боловсруулахыг энэ дүрмээр шаардана. Журамд зорчигч, ажилтан, тээш, ачаа, агаарын хөлгийн эд ангид нэвтрэхэд тавих хяналтыг тусгасан байна. Агаарын тээвэрлэгч нь өөрийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт журмыг

Дээр дурдсан байгууламжид зөвшөөрөлгүй этгээд нэвтэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх дэс дараатай арга хэмжээг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгана:

(а) дээрх байгууламжид зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; эсхүл

(b) нэвтрэх хяналтыг хэн нэгэн зөрчсөн тохиолдолд саатуулах

Агаарын хөлгийн ашиглалтын аюулгүй байдал болон аюулгүй ажиллагаатай холбоотой эрсдэлийг багасгахын тулд шаардлагатай нөхцөлд агаарын хөлөгт аюулгүйн хамгаалалтын шалгалт хийх арга хэмжээг нарийвчлан заасан байна.

Агаарын тээвэрлэгчийн үүрэг хариуцлага нь ИНД-140 Хавсралт А.27-гийн шаардлагад суурилсан байна.

*Хэн ч хууль ёсны зөвшөөрөлгүйгээр-*

*(1) аэродромын аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс, үйл ажиллагааны бүс рүү нэвтрэх хаалга, хаалтыг хяналтгүй, нээлттэй орхих.*

**108.55(b)(5) Түр хугацаатай аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээ**

Агаарын тээвэрлэгч нь Дарга аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэн гэж сэжиглэж байгаа бөгөөд энэ нь аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээг авахыг шаардаж байгаа бол энэ үед хэрэгжүүлэх журам боловсруулахыг энэ дүрмээр шаардана.

ИНД-129-ын дагуу гэрчилгээжсэн Монгол Улсад, эсхүл Монгол Улсаас нислэг үйлдэж байгаа агаарын тээвэрлэгч нь аюулгүйн хамгаалалтыг сайжруулах түр арга хэмжээг авч хэрэгжүүлэх журам боловсруулна. Агаарын тээвэрлэгч нь Даргын онцолсон аэродромд үйлдэх бүх нислэгт зориулсан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг боловсруулсан байна.

**Rule 108.55(b)(6) Тээш, ачаа, илгээмж, шуудан, агаарын хөлгийн хангамжийн эд зүйлсийн хамгаалалт**

Энэ дүрмээр тээш, ачаа, илгээмж, шуудан, агаарын хөлгийн хангамжийн эд зүйлсийн зохих аюулгүйн хамгаалалтын хяналтын журам боловсруулахыг шаардана.

## **Тээш**

Агаарын тээвэрлэгчийн зорчигчийн тээшийг хүлээж авснаас хойш тээш байгаа газарт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх журмыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөртөө тусгасан байна. Агаарын тээвэрлэгчийн хамгаалалтад авсан тээшийг аюулгүй газар байлгана.

Олон улсын нислэг үйлддэг аэродромын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд тээш ялгах хэсгийг зохион байгуулах ба аюулгүйн үзлэг хийсэн тээшийг хамгаална. Тээшинд тавигдах тусгай шаардлагын нарийвчилсан зааварчилгааг Хавсралт I болон II-г тусгасан болно.

### **Тээш, шуудангийн илгээмж, буухиа илгээмж болон шуудан**

Энэ дүрмийн 108.55(с)-д дээрх эд зүйлийн аюулгүйн хамгаалалтын хяналтын шаардлага болон цаашид авах арга хэмжээг нарийвчлан тусгасан байна.

Аэродром, ачаа ялгах хэсэгт шилжүүлэх ачаа, шуудангийн хамгаалалт нь 108.55(10)-ын шаардлагыг хангах ба цаашид авах арга хэмжээг нарийвчлан тусгасан болно.

### **108.55(b)(7) Хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх- нислэгийн аюулгүй байдал**

Агаарын тээвэрлэгч нь хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэхдээ нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах журам боловсруулсан байна. Зорчигч нь харгалзагчтай байгаа, эсхүл хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа эсэхээс үл хамааран тухайн журам үйлчилнэ.

#### ***Мөн 108.55(f)-ийг мөрдөнө.***

Зорчигч тээврийн арилжааны нислэгээр хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх тохиолдолд 108.58-д заасны дагуу Монгол Улсын болон гадаадын төрийн байгууллага нь агаарын тээвэрлэгчид мэдэгдсэн байх шаардлагатай. Агентлаг нь санал болгосон аяллын нөхцөл байдлыг агаарын тээвэрлэгчид мэдэгдэх ёстой. Агаарын тээвэрлэгч зөвшөөрсөн тохиолдолд агаарын хөлгийн даргад мэдэгдэнэ. Оролцогч агентлаг нь тухайн агаарын тээвэрлэгчийн тогтоосон бүх нөхцөлийг дагаж мөрдөх ёстой.

108.55(b)(7)-д заасан журамд дараах шаардлагыг тусгасан байна:

(а) эдгээр хүмүүсийг тээвэрлэснээр нислэг болон бусад зорчигч, нисэх бүрэлдэхүүний эсрэг ямар ч заналхийлэлгүй, эсхүл эрсдэл багасгах арга хэмжээ авах;

(b) аюулгүй ажиллагаанд харшилна гэж агаарын тээвэрлэгч үзсэн тохиолдолд хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэхээс татгалзах;

(c) тухайн этгээдийг нэг агаарын тээвэрлэгчийн нислэгээс өөр агаарын тээвэрлэгчийн нислэгт шилжүүлэн суулгах бол нислэг эхлэхээс өмнө холбогдох байгууллагад мэдэгдэх арга хэмжээг авах;

(d) хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх тохиодолд 108.55-д заасны дагуу дараах шаардлагыг биелүүлсэн байх:

- (1) цагдаагийн байгууллагын хяналтад байгаа этгээдийг олон улсын тогтмол нислэгээр тээвэрлэх тохиолдолд нэг хүнд нэг, эсхүл түүнээс дээш тооны харгалзчтай тээвэрлэх;
- (2) агаарын тээвэрлэгч олон улсын тогтмол нислэгээр хоригдол тээвэрлэх тохиолдолд нисэн хүрэх улсын холбогдох байгууллагатай урьдчилан тохиролцсон байх;
- (3) зэвсэг болгон ашиглаж болох аюултай хэрэгсэл авч яваагүй болохыг харгалзагч шалгаж бататгасан байх;
- (4) харгалзагч нь саатуулах шаардлагатай арга хэмжээг авахад ашиглах номхотгох хэрэгсэлтэй байх. Номхотгох хэрэгслээр хоригдлыг агаарын хөлгийн аль ч хэсэгт гинжлэхгүй байх;
- (5) харгалзагч, хүчний байгууллагын ажилтан нь нислэг үйлдэх болон аяллын туршид шилжин, дамжин суух цэгийн аюулгүйн хамгаалалтын ажилтан, ажил үүргээ гүйцэтгэж байгаа хууль хяналтын байгууллагын ажилтанд танигдахуйц байх;
- (6) агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн дарга болон ахлах үйлчлэгч хоригдол, эсхүл хоригдлууд, түүний харгалзагчийн талаар мэдсэн байх ба аюулгүйн хамгаалалтын урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, суудлын хуувирлалтыг хийх;
- (7) хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг бусад зорчигчоос өмнө агаарын хөлөгт суулгаж, бусад зорчигч бүгд буусны дараа агаарын хөлгөөс гаргах;
- (8) хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээд, түүний харгалзагчийг агаарын хөлгийн арын суудалд гарах хаалганаас хол суулгах;
- (9) агаарын хөлгийн суудлын зохион байгуулалтаас хамаарч хууль, цагдаагийн хяналтад байгаа этгээд, түүний харгалзагчийг суулгах ба хоёр этгээд авч яваа тохиолдолд харгалзагчийг дунд нь суулгана. Боломжгүй тохиолдолд харгалзагчийг тухайн этгээдийн өөдөөс харуулж суулгах;
- (10) харгалзагч хууль, цагдаагийн хяналтад байгаа этгээдийг байнга дагах;
- (11) хууль, цагдаагийн хяналтад байгаа этгээд, түүний харгалзагч нарт спиртийн төрлийн ундаа, хоолны төмөр хэрэгслээр үйлчлэхгүй байх;
- (12) агаарын тээвэрлэгч болон хамгаалалтын агентлагаас тухайн этгээдийг аюултай гэж үзсэн тохиолдолд 2-оос доошгүй харгалзагчаар хангах. Нэг нислэгээр хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа нэг этгээд, түүний харгалзагчийг зөөвөрлөх;
- (13) ямарч нөхцөлд, агаарын тээвэрлэгч нь 108.55(с)(9)-д заасны дагуу нэг нислэгээр зөөвөрлөх хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийн тоонд хязгаарлалт тогтооно-



- 29-өөс дээш суудалтай агаарын хөлөгт хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа нэг этгээд;
- нэмэлт 25 суудал тутамд хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа нэг этгээдийг цаашлаад нэмэх;

Хуудас 10-ын Хүснэгт 1-ээс агаарын хөлгийн суудлын тооноос хамаарч тээвэрлэх этгээдийн тоог харах.

(е) агаарын тээвэрлэгч оюун санааны хомсдолтой этгээд тээвэрлэх нь аюултай гэж үзсэн тохиолдолд дараах арга хэмжээг авна:

- шаардлагатай үед тухайн хүмүүсийн үйлдлийг зогсоож чадах бие бялдрын хөгжилтэй хүн дагаж явах;
- тухайн этгээдийг дагалдан яваа хүнд шаардлагатай эм тариа байгаа эсэхийг шалгах;
- нисэн гарахаас өмнө номхруулах эм, тариа хэрэглэдэг бол нислэгийн хугацаа тухайн эм, тарианы үйлчилгээ дуусахаас бага байх шаардлагатай тул үүнийг судалж тухайн этгээдийг тээвэрлэх.

(f) Монгол Улсаас албадан гаргаж байгаа болон хууль зөрчсөн гадаадын иргэдийг агаарын хөлгөөр тээвэрлэн гаргахад нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх эсэхийг үнэлэн дүгнэсэн байх шаардлагатай. Энэхүү үнэлгээг агаарын тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэх ба аюулгүй байдалд эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд агаарын тээвэрлэгчийн нисэхийн аюулгүйн хамгаалалтын мэргэжилтэнтэй зөвшилцөж шийднэ. Үүнийг үндэслэж агаарын хөлгийн бүхээгт байгаа хүмүүс болон нислэгийн аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээ авах эсэхийг агаарын тээвэрлэгч тогтооно.

#### **108.55(b)(8) Дамжих болон шилжин суух зорчигч, тэдгээрийн гар тээшний хяналт**

Агаарын хөлөгт хориглосон эд зүйлс авч орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дамжин болон шилжин суух зорчигч, тэдгээрийн гар тээшинд үзлэг хийх журмыг агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан байхыг энэ дүрмээр шаардана. Хориглосон эд зүйлс агаарын хөлөгт авч орох эрсдэлээс урьдчилан сэргийлэх журмыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай. Дамжин болон шилжин суух зорчигч аюулгүйн үзлэг хийгдээгүй өөрсдийн тээшинд хүрэх, эсхүл аюулгүйн үзлэгт хамрагдаагүй хүмүүстэй уулзах зэрэгт Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага, эсхүл агаарын тээвэрлэгч хяналт тавьж ажиллах хэрэгтэй.

#### **108.55(b)(9) Дамжин суух зорчигч- гар тээшний хяналт**

Дамжин суух нислэгийн зорчигч агаарын хөлгөөс буухдаа гар тээш, эд зүйлсээ орхиогүй гэдэгт хяналт тавих журам боловсруулсан байхыг энэ дүрмээр шаардана. Энэ шаардлага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах аль нэг аэродромыг дайран өнгөрөх ИНД-129 болон ИНД-119-ын дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгч бүрд үйлчилнэ.

Дамжин өнгөрөх зогсоолд дамжин суух зорчигч гар тээш, эд зүйлсээ агаарын хөлөгт орхиж буух нь илүү тохиромжтой юм. Энэ тохиолдолд агаарын

тээвэрлэгч нь дамжин суух зорчигчийн эд зүйлд зөвшөөрөлгүй хүрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг заасан журмыг боловсруулсан байна.

Дамжин суух зорчигчийн эд зүйлд зөвшөөрөлгүй хүрэхээс урьдчилан сэргийлэх журамд дараах шаардлагыг тусгана:

- дамжин өнгөрөх зогсоолд агаарын хөлгийг орхиж дамжин суух зорчигч гар тээш болох бүх эд зүйлсээ агаарын хөлгөөс авч буух;
- дамжин өнгөрөх зогсоолд агаарын хөлөгт авч яваа эд зүйлсээ орхихыг зөвшөөрөх агаарын тээвэрлэгч нь уг эд зүйлд зөвшөөрөлгүй хүрэхээс урьдчилан сэргийлсэн журамтай байх;
- агаарын тээвэрлэгч нь эд зүйлд зөвшөөрөлгүй хүрэхээс урьдчилан сэргийлж, хамгаалалтын арга хэмжээ авах ба зорчигч буцаж агаарын хөлөгт суухдаа өөрсдийн эд зүйлсийг хялбар таних нөхцөлийг бүрдүүлэх;
- агаарын тээвэрлэгчийн хяналтад үлдээсэн эд зүйлсийг аюулгүй орчинд хамгаалах;
- агаарын тээвэрлэгч нь дамжин өнгөрөх зогсоолд агаарын хөлгөөс буусан болон агаарын хөлөгт буцаж суугаагүй зорчигчийг тогтоох журам боловсруулсан байна. Уг дамжин суух зорчигчийн гар тээш, эд зүйлсийг агаарын хөлгөөс буулгах.

#### **108.55(b)(10) Ачаа, түүнийг зөөвөрлөх хөдөлгөөний хамгаалалт**

Олон улсын агаарын тээврийн зорчигч үйлчилгээний агаарын хөлгөөр тээвэрлэх ачаа, тээш, шуудан, хөрөнгө, агаарын хөлгийн хангамжийн хэрэгслийг зөөвөрлөх, хөдөлгөөний журам боловсруулахыг энэ дүрмээр шаардана. Энэ үйл ажиллагаа нь аюулгүй, эсхүл аюулгүй байдлыг хангаагүй орчноос үл хамааран хийгдэнэ.

Зөөвөрлөх хөдөлгөөн нь зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай эд зүйл нэвтрүүлэхээс сэргийлж, холбогдох хяналтын дор явагдана.

#### **Ачаа ба Шуудан**

Энэ дүрмийн 108.55(d)(1)-ийн дагуу ачаа болон шууданг аэродромын нэвтрэх хяналттай бүсэд хадгална.

Үүнтэй холбоотой бусад нарийвчилсан зүйлийг 109.53-ын дагуу боловсруулсан АС 109-1-ээс олж болно.

ИНД-ийн нэр томъёоны тайлбар болон 1999 оны Иргэний нисэхийн тухай хуулийн Бүлэг 3-т тодорхойлсны дагуу энд дурдсан аэродром гэх тодорхойлолтод барилга байгууламж, төхөөрөмж, эсхүл аэродром, эсхүл түүний захиргаатай холбоотой ашиглаж буй түүний ойролцоох бүс хамрагдана.

#### **Тээш**

Агаарын тээвэрлэгч нь зорчигчийн тээшийг хүлээн авснаас хойш болон аэродромын дотор зөөвөрлөхөд зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэх журам боловсруулж, аюулгүйн хамгаалалтын хөтөлбөртөө тусгана. Тээшийг агаарын тээвэрлэгчийн хамгаалалтад, аюулгүй орчинд бэлтгэнэ. Олон улсын

нислэгт үйлчлэх аэродромын хориотой бүсэд байрлах тээш бэлтгэх хэсэгт үзлэгийг хийж, аюулгүй байдлыг баталгаажуулах ба тухайн бүсэд энгийн нэвтрэх хяналтыг тогтооно. Тээшний аюулгүй байдлыг хангах онцгой шаардлагын талаарх зааварчилгааг Хавсралт I болон II-оос харна уу.

### **Нөөц бүтээгдэхүүн болон агаарын хөлгийн хангамжийн хэрэгсэл**

Энэхүү шаардлага нь нөөц бүтээгдэхүүн болон агаарын хөлгийн хангамжийн хэрэгсэл, нислэгийн хоол хүнстэй холбоотой болно. Нөөц бүтээгдэхүүн, агаарын хөлгийн хангамжийн хэрэгсэл болон нислэгийн хоол хүнсийг аюулгүй орчинд бэлтгэх журамтай байна.

Аэродромын дотор талд нөөц бүтээгдэхүүн болон агаарын хөлгийн хангамжийн хэрэгслийн тээвэрлэлтийг хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай эд зүйл агаарын хөлөгт авч орохоос сэргийлэхээр зохион байгуулна.

Агаарын хөлөгт тухайн зүйлийг хүргэх тээврийн хэрэгсэл, төхөөрөмж, контейнерыг аюулгүй орчинд байлгах буюу аюулгүй байдлыг хангахын тулд ашиглахаас нь өмнө шалгасан байна.

Ачаа, тээш, шуудан агаарын хөлгийн хангамжийн хэрэгсэл, нөөц бүтээгдэхүүн, эсхүл агаарын тээвэрлэгчийн бараанд ямар нэгэн сэжигтэй зүйл илэрсэн, эсхүл сэжиглэл бий болсон үед үзлэг, шалгалт явуулах ба аюулгүйн хамгаалалтын бусад арга хэмжээг авч аюулгүй гэж үзсэн тохиолдолд ачилтыг үргэлжлүүлнэ.

### **108.55(b)(11) Ачаа, эсхүл шуудангаас бусад илгээх барааны баглаа боодлын аюулгүйн үзлэг**

Энэ дүрмээр ачаа, шуудангаас тусад нь тээвэрлэх илгээмжийн аюулгүйн үзлэг, шалгалтын журмыг агаарын тээвэрлэгч боловсруулсан байхыг шаардана.

Дипломат шуудантай холбоотой тусгай зааварчилгааг энэ АС-108.55(i)(1)-д тусгасан болно.

Уг бараанд зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай эд зүйл байхгүй болохыг бататгах зорилгоор аюулгүйн хамгаалалтын тусгай хяналтын арга хэмжээ авна.

Журамд дараах зүйлийг тусгана:

(а) рентген туяаны төхөөрөмж, эсхүл гараар шалгана. Үзлэгийн ажилтан нь рентген туяаны төхөөрөмжөөр зэвсэг, тэсрэх бодис, эсхүл аюултай эд зүйл байхгүй болохыг бататгаж чадаагүй нөхцөлд гараар шалгана;

(б) шалгалтыг аюулгүй орчинд гүйцэтгэнэ;

(с) агаарын хөлөгт ачих хүртэл аюулгүйн үзлэг хийсэн барааны аюулгүй байдлыг хангана.

Аюулгүйн хамгаалалтын хувьд дээрх шаардлагыг хангасан илгээмжийг тээвэрлэхийг агаарын тээвэрлэгч зөвшөөрнө. Аюулгүйн үзлэг, шалгалтыг сургалтад хамрагдсан, мэдлэг чадвартай хүн хийж гүйцэтгэнэ.

**108.55(b)(12) Зорчигч болон багийн гишүүдэд аюулгүйн үзлэг хийх**

Агаарын тээвэрлэгч нь зорчигч, багийн гишүүд болон тэдгээрийн гар тээшинд олон улсын зорчигч тээврийн нислэг үйлдэх агаарын хөлгийн бүхээгт нэвтрэхээс өмнө аюулгүйн үзлэг хийсэн байх журмыг боловсруулж аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан байна.

Энэ нь олон улсын зорчигч тээврийн нислэг үйлдэх агаарын хөлгийн бүхээгт хориглосон эд зүйлс оруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм.

Бүх зорчигч, тээшний аюулгүйн үзлэгийг 108.63-т заасны дагуу гүйцэтгэнэ. Монгол Улсад нисэхийн аюулгүйн үзлэгийг Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага, эсхүл түүний шууд хяналтан дор ажиллах ажилтан гүйцэтгэнэ.

Аюулгүйн үзлэгийг үзлэгт хамрагдсан этгээд аюулгүйн үзлэг хийлгээгүй хүнтэй уулзах боломжгүй орчинд гүйцэтгэх шаардлагатай.

Агаарын хөлгөөр зорчих аюулгүйн үзлэг хийлгэсэн этгээд үзлэгт хамрагдаагүй хүнтэй уулзсан, эсхүл эд зүйл авсан тохиолдолд үзлэгийн цэг, нисэн гарах агаарын хөлгийг хааж агаарын хөлөгт суусан болон үзлэгийн дараах бүсэд байгаа хүмүүст, мөн агаарын хөлөгт дахин үзлэг шалгалт хийнэ.

Аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан этгээдийг агаарын тээвэрлэгч тээвэрлэхгүй байх эрхтэй.

Ажлын айлчлал хийж буй Хаан болон улсын тэргүүн, тэдгээрийн гэр бүлийн хүнийг зорчигчийн аюулгүйн үзлэгээс чөлөөлнө. Тухайн этгээд холбогдох хамгаалалттай нөхцөлд энэ шаардлага үйлчлэх ба албан ёсны хамгаалалтын тал нь тэдгээрийн тээшний аюулгүй байдлыг хариуцна. Энэхүү чөлөөлөх шаардлага нь Хаан, эсхүл улсын тэргүүнтэй хамт аялж байгаа бусад хүмүүст үйлчлэхгүй болно.

**108.55(b)(13) Зорчигч, тээшний тулгалт**

Энэ дүрмээр агаарын тээвэрлэгчийг зорчигч, тээшний тулгалтыг үнэн зөв хийх журам боловсруулж, аюулгүйн хамгаалалтын хөтөлбөртөө тусгахыг шаардана.

Уг журам нь зорчигчийн бүртгэгдсэн тээшинд тавих аюулгүйн хамгаалалтын бусад арга хэмжээ дээр нэмэлт болно. Журам нь олон улсын нислэгээр зорчих бүх бүртгүүлсэн хүмүүс, дамжин, эсхүл шилжин суух зорчигч, агаарын хөлөгт суух, эсхүл дахин суусныг баталгаажуулахад хангалттай байна. Бүртгэсэн тээшийг хүлээж авсны дараа зорчигч агаарын хөлөгт суугаагүй, эсхүл дахин суугаагүй тохиолдол бүрд тээшийг агаарын хөлөгт ачихгүй ба, эсхүл ачсан бол агаарын хөлөг нисэн гарахаас өмнө буулгасан байх ёстой. Ийм тээшийг холбогдох сургалтад хамрагдсан, мэдлэг чадвартай аюулгүйн хамгаалалтын ажилтан тусгай үзлэг шалгалт хийхээс өмнө дахин олон улсын зорчигчийн агаарын хөлөгт ачихыг хориглоно. Аюулгүйн үзлэг шалгалтад рентген төхөөрөмж ашиглахаас гадна түүнийг гараар шалгасан байна.

Агаарын тээвэрлэгч нь зорчигчоос үл хамаарах дараах нөхцөл байдлын улмаас зорчигч агаарын хөлөгт нэвтэрч, эсхүл дахин сууж чадаагүй тохиолдолд тээшийг үлдээх журмыг боловсруулсан байна:

- (а) зорчигч бүртгүүлсний дараа агаарын хөлөг нисэн гарахаас өмнө нас барсан;
- (б) үйл ажиллагааны хүчин зүйл болох цаг агаар, эсхүл техникийн шалтгааны улмаас нислэг хойшлогдох, цуцлагдах, эсхүл 'анх төлөвлөсөн нислэгээр хүрэх аэродромын үйл ажиллагааны нөхцөл зэргээс хамаарч зорчигч өөрөө өөр нисэх буудал дээр буух шийдвэр гаргасан;
- (с) агаарын тээвэрлэгч нь жин, эсхүл ижил төрлийн үйл ажиллагааны шаардлагын улмаас тээш, эсхүл зорчигчийн маршрутыг дахин тогтоохдоо зорчигчийг хүлээлгүй тээшний бүртгэлийг хийнэ.

Дээрх журамтай холбоотой шийдвэр гаргах үйл явцыг баримтжуулах ба үүнд нисэн гарах агаарын хөлгийн даргатай зөвшилцсөн байх асуудал мөн багтсан байна. 108.55(b)(17)-д заасан зорчигч, тээш тулгах журмыг хэрэгжүүлнэ.

#### **108.55(b)(14) Нислэг эхэлж буй агаарын хөлгийн нислэгийн өмнөх үзлэг**

Энэ дүрмээр агаарын тээвэрлэгч нь нислэг эхэлж буй агаарын хөлөгт нислэгийн өмнөх аюулгүйн үзлэг хийх журмыг боловсруулсан байна. Агаарын хөлөгт зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай эд зүйл нуусан байж болзошгүйг илрүүлэх зорилгоор уг журмыг боловсруулна.

*Нислэг эхэлж буй агаарын хөлөг* гэж өмнөх нислэгийн төгсгөлд зорчигч, барааг буулгаж, хоосон болгосон Монгол Улсын аль ч аэродромоос тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээ үзүүлэхэд ашиглах агаарын хөлгийг ИНД-ийн нэр томъёоны тайлбарт тодорхойлсон болно, гэхдээ (Монгол Улсыг дамжин өнгөрч байгаа, эсхүл Монгол Улсын аль ч аэродромоос зорчигч, бараа нэмсэн агаарын хөлөг хамрахгүй).

Энэ дүрэмд нийцсэн агаарын хөлгийн шалгалтыг агаарын хөлгийн нислэгийн, эсхүл бүхээгийн баг нислэгийн өмнөх үзлэгийн журмын дагуу гүйцэтгэнэ. Аюулгүйн үзлэг хийлгээгүй хүмүүсийг тээвэрлэх үйлчилгээнд ашиглаж байсан агаарын хөлгөөр олон улсын нислэг үйлдэх үед агаарын хөлгийг холбогдох сургалтад хамрагдсан, чадварлаг боловсон хүчнээр агаарын хөлгийн шалгалтыг хийлгэнэ.

#### **108.55(b)(15) Нисэх буудлын бүртгэлийн цэгээс өөр газраас эхлэлтэй тээш**

Энэ дүрэм нь ачааны байгууламж болон агаарын ачаанд тавигдах аюулгүйн хамгаалалтын шаардлагыг хангаж хүлээн авсан, ачааны нэгэн адил тээвэрлэгдэх тээшинд үйлчлэхгүй болно.

Агаарын тээвэрлэгч нь тээшний аюулгүй байдлыг хангах журам боловсруулахыг шаардана:

- (а) хэмжээ болон бусад шалтгааны улмаас нисэх буудлын бүртгэлээс өөр газар тээвэрлэхээр хүлээн авсан;
- (б) эзэнгүй тээш, эсхүл танигдаагүй тээш;

(с) энгийн нисэх буудлын гаднах бүртгэлээс эхлэлтэй тээш.

108.63-т заасан шаардлагын дагуу дээр дурдсан тээшинд агаарын хөлгийн эсрэг хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, эсхүл хэрэгсэл байхгүй болохыг бататгах аюулгүйн хамгаалалтын журамд тээшинд аюулгүйн үзлэг хийх батлагдсан аргачлалыг тусгасан байна.

108.55 (b)(17)-д заасан Тээшийг баталгаажуулах журмыг мөн адил хэрэгжүүлэх шаардлагатай.

Дээрх заалтын (с) ба (d)-гийн хувьд тээшинд үзлэг хийх, бүртгэх, тээш ялгах, агаарын хөлөгт хүргэх аюулгүйн хамгаалалтын журам нь энгийн нисэх буудлын бүртгэл дээр хийгддэг журмаас бага түвшинд байж болохгүйг баталгаажуулсан байна. Агаарын тээвэрлэгч нь (с) болон (d)-д заасан тээшийг хүлээж авахгүй тохиолдолд операторын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт байгаа мэдэгдэл нь нийцлийн хувьд хангалттай байх болно.

#### **108.55(b)(16) Тээшний аюулгүйн үзлэг**

108.63-т заасны дагуу олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний агаарын хөлөгт тээшийг ачихаас өмнө үзлэг хийсэн байх журмыг энэ дүрмээр шаардана. Тээшний үзлэгийн хэрэгжүүлэлтийн зөвшөөрхүйц хэлбэрийг Хавсралт I-д нарийвчлан тусгасан болно.

#### **108.55(b)(17) Тээшний баталгаажуулалт**

Олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний агаарын хөлөгт ачих бүх тээшийг баталгаажуулсан байхыг энэ дүрмээр шаардана. Тээшний баталгаажуулалтын хэрэгжүүлэлтийн хүлээн зөвшөөрхүйц хэлбэрийг Хавсралт II-т нарийвчлан тусгасан болно.

#### **108.55(b)(18) Нислэгийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх**

Энэ дүрмээр агаарын тээвэрлэгчийг агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлгийн маяг, тохиргоотой холбоотой журам боловсруулахыг шаардана. Эдгээр журмыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр эсхүл агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны зааврын холбогдох хэсэгт тус тус тусгасан байна.

Нисэх багийн бүхээгийн хаалгатай агаарын хөлгийн хувьд нислэгийн үед зайлшгүй нэвтрэх шаардлагатай бол нислэгийн нисэх багийн бүхээгийн хаалга онгорхой үед зөвшөөрөлгүй этгээд орохгүй байх аргачлалыг тусгасан журамтай байна.

Агаарын хөлгийн нисэх багийн бүхээгнээс хүн гарахыг хүссэн тохиолдолд хаалгыг нээхээс өмнө дараах зүйлийг авч үзэх шаардлагатай:

- нисэх багийн бүхээгтэй ойролцоох ариун цэврийн хэсэгт зорчигч байхгүйг баталгаажуулах;

- өндөр эрсдэлтэй нислэг, эсхүл танихгүй зорчигч хаалгаар хялбар нэвтрэх боломжтой зэрэг хаалганы гадна тал дахь нөхцөл байдлыг тодорхойлох;
- хаалга нээлттэй үед бүхээгийн ажилтан зорчигчийг шууд орохоос хамгаалаж зогссоныг баталгаажуулах.

Нисэх багийн бүхээгийн хаалгыг зөвхөн хурдан гарах, эсхүл ороход шаардагдах минимум хугацаанд онгойлгоно. Нисэх багийн бүхээгт нэвтрэх зөвшөөрлийг агаарын хөлгийн дарга өгөх ба үүнтэй холбоотой журмыг боловсруулсан байна. Зөвхөн агаарын хөлгийн даргын зөвшөөрсөн хүн нэвтрэхийг зөвшөөрнө.

Нисэх багийн бүхээгт нэвтрэх этгээдэд зөвшөөрөл олгох журмыг баримтжуулж, хүний тоо минимум хэмжээнд байна.

### **108.55(с)(1) Зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас хүлээн авсан ачаа ба шуудан**

Агаарын тээвэрлэгч нь өөрийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас ачаа ба шуудан хүлээн авах журмыг тусгасан байна. Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын жагсаалтыг [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) - хуудаснаас харж болно.

Журам нь агаарын тээвэрлэгчийн зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас хүлээн авах ачаа аюулгүйн хамгаалалтын мэдэгдэх хуудастай байх шаардлагыг баталгаажуулсан байна. Иргэний нисэхийн ерөнхий газар нь мэдэгдэх хуудасны тодорхой маягт санал болгохгүй ба уг хуудас шаардлагатай мэдээлэл агуулсан байхыг шаардана. Аюулгүйн хамгаалалтын мэдэгдэх хуудас нь ИНД-109-ийн Хавсралт А-д заасан мэдээллийг агуулсан байна.

Аюулгүйн хамгаалалтын мэдэгдэх хуудсыг Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурна.

Баримт бичиг бүрдүүлэх үйл ажиллагаанд агаарын тээвэрлэгчийн Зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас хүлээж авах ачаа, шуудан гэмтээгүй болохыг хянах аргачлалыг багтаасан байна. Агаарын тээвэрлэгч нь зохих журмыг боловсруулж, өөрийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт оруулах, эсхүл Зохицуулалттай агаарын ачааны байгууллага бүрд зориулсан журмыг боловсруулж хүргүүлнэ.

Зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас ачаа, эсхүл шууданг аюулгүйн хамгаалалтын мэдэгдэх хуудасгүй хүлээж авсан тохиолдолд 108.55(с)(2)-т заасан аюулгүйн хамгаалалтын зохих хяналтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### **108.55(с)(2) Бусад этгээдээс хүлээж авсан ачаа болон шуудан**

Агаарын тээвэрлэгч нь Зохицуулалттай агаарын ачааны байгууллага бус өөр байгууллагаас ачаа болон шуудан хүлээн авах журмыг боловсруулсан байна. Уг журам нь энэ дүрэмд шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын арга хэмжээг багтаасан байна.

Агаарын тээвэрлэгч нь зөвхөн ЗААБ-аас ачаа болон шуудан хүлээж авах бол байгууллагын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт уг бодлогоо тусгах ба 108.55(d)-д заасан журмыг боловсруулах шаардлагагүй юм.

#### **108.55(d) Ачаа, шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналт**

Агаарын тээвэрлэгч нь ЗААБ-аас өөр бусад хүнээс ачаа, шуудан хүлээж авахад зориулж ИНД-109-ийн шаардлагад нийцсэн 108.55(c)(2)-д заасан аюулгүйн хамгаалалтын хяналтын арга хэмжээг багтаасан зохих журам, байгууламжийг бэлтгэсэн байна:

- (1) 109.53 (Байгууламжийн шаардлага);
- (2) 109.55 (Ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журам);
- (3) 109.57 (Аюулгүйн үзлэгийн журам);
- (4) 109.59 (Зөвшөөрөл олгох журам);
- (5) 109.61 (Бүртгэлтэй харилцагчийг бүртгэх журам);
- (6) 109.63 (Ажилтнуудын сургалт);
- (7) 109.65 (Ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил);
- (8) 109.67 (Бүртгэл хөтлөх).

Дээрх шаардлагатай холбоотой зөвлөмжийн мэдээлэл нь АС-109-1-д байгаа болно.

#### **108.55(e) Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт багтсан ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналт**

Энэ дүрмийн 108(d)-д заасан аюулгүйн хамгаалалтын хяналтыг хэрэгжүүлэх зохих баримт бичиг, журам нь агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт бүрэн тусгагдсан байх шаардлагагүй юм. ИНД-108-д шаардсаны дагуу аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт дээрх журам, мэдээллийг багтаасан баримт бичгийг ерөнхий байдлаар оруулах шаардлагатай болно.

#### **108.55(g) Олон улсын агаарын үйчилгээнд тээвэрлэхээр хүлээн авсан зорчигч болон тээш**

Энэ дүрмээр тээшийг олон улсын зорчигч үйлчилгээнд тээвэрлүүлэхээр шилжүүлэхээс өмнө орон нутгийн агаарын тээвэрлэгч нь тээшийг орон нутагт тээвэрлэхээр хүлээн авсан байх зорчигч, тээшний журмыг боловсруулахыг шаардана.

Журам нь тээш бүртгэлээс олон улсын тээвэрлэгч хүлээн авах хүртэл хэрэгжүүлэх аюулгүйн хамгаалалтын арга хэмжээг тогтоох ба олон улсын агаарын тээвэрлэгч шууд хүлээн авах олон улсын тээшний адил аюулгүй байна. Эдгээр журам нь 108.63-ын дагуу орон нутгийн тээшийг олон улсын нислэгт шилжүүлэхэд мөрдөх арга хэрэгслийг тогтоосон байна.



**108.55(h) Олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах тээш**

Монгол Улсаас үйлдэгдэх олон улсын нислэгээс нөгөө олон улсын нислэгт тээшийг шилжүүлэх, дамжуулах бол Иргэний нисэхийн тухай хуулийн 40.1-д заасны дагуу дахин аюулгүйн үзлэгт хамруулна. Агаарын тээвэрлэгч нь тээшийг нислэг эхлэхээс өмнө аюулгүйн үзлэг шалгалтад хамруулах зорилгоор Нисэхийн аюулгүйн хамгаалалтын албанд хүргэж өгнө.

**108.55(i)(1) Дипломат шуудан**

Албан ёсны дипломат байгууллагын зохих албан тушаалтны гарын үсэг зурсан дагалдах баримт бичигтэй, лацадсан, холбогдох тэмдэг, тэмдэглэгээ хийгдсэн дипломат илгээмжийг 108.55(c)(1) болон (2)-д заасан аюулгүйн хамгаалалтын хяналтын шаардлагаас чөлөөлнө.

Дипломат шууданг шуудан зөөгч дагалдах тохиолдолд түүнд энэ АС-ийн дагуу бусад зорчигчийн нэгэн адил үзлэг шалгалт хийнэ.

**108.55(i)(2) Олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах ачаа ба шуудан****Олон улсын дамжин өнгөрөх ачаа, эсхүл шуудан**

Монгол Улсад олон улсын нислэгээр тээвэрлэж авчирсан ачаа, эсхүл шууданг агаарын хөлгөөс буулгахгүй, тухайн агаарын хөлгөөр үргэлжлүүлэн тээвэрлэх бол 108.55(c)(1) болон (2)-д заасан аюулгүйн хамгаалалтын хяналтын арга хэмжээг авах шаардлагагүй ба агаарын хөлгийг аюулгүйн хамгаалалттай аэродромын хориотой бүсэд байрлуулах ба ИНД-108-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын арга хэмжээг авна.

**Олон улсын дамжин өнгөрөх ачаа, эсхүл шуудан**

Монгол Улсад олон улсын нислэгээр тээвэрлэж авчирсан ачаа, эсхүл шууданг өөр олон улсын нислэгт шижүүлэн зөөвөрлөх бол 108.55(c)(1) болон (2)-т заасан аюулгүйн хамгаалалтын хяналтын арга хэмжээнд хамруулахгүй ба 108.55(b)(10)-д заасан хяналтын холбогдох арга хэмжээг авсан байна.

**108.57 Нислэгт олгох аюулгүйн хамгаалалтын зөвшөөрөл**

Аливаа агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөг энэ дүрэм, дүрмээр шаардсан журам, аюулгүйн хамгаалалтын холбогдох шаардлагыг хангаагүй тохиодолд нислэг үйлдэхгүй болохыг баталгаажуулсан байна.

Агаарын хөлөг нисэн гарахаас өмнө агаарын тээвэрлэгчийн төлөөлөгч, эсхүл хариуцсан менежер нь агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан журмыг тухайн нислэгт хангасан болохыг баталгаажуулах ёстой.

Чанарын хяналтын тогтолцоо бүрдүүлэн хэрэгжүүлж байгаа байгууллагын хувьд зөвшөөрөл нь автоматжуулагдсан байна. Энэхүү тогтолцоо нь агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын мэргэжилтнүүд хөтөлбөр болон аюулгүй байдлын журмын хэрэгжилтийг тогтмол хугацаанд шалгах, эсхүл өөр байнгын

дотоод аудитын аргачлалыг багтаана. Шалгалтыг баримтжуулах нь ИНЕГ-ын аюулгүйн хамгаалалтын байцаагч, агаарын тээвэрлэгч холбогдох үзлэг шалгалт хийж шаардлагатай залруулах, эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгааг баталгаажуулахад шаардлагатай юм.

### **108.59 Ажилтны сургалт**

ИНД-119 болон ИНД-129-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгч нь 108.59-ийн шаардлагад нийцүүлэн ажилтнаа сургасан байна.

ИНД-129-ийн дагуу агаарын тээвэрлэгчийн хувьд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа агаарын тээвэрлэгч, эсхүл агентлагийн ажилтан, эсхүл Монгол Улсад хэрэгжүүлэх агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг гүйцэтгэхэд оролцох ажилтныг энэ дүрмийн сургалтад тавих шаардлагын дагуу сургана.

108.59-д шаардсан сургалтыг ерөнхий захирал хүлээн зөвшөөрсөн, тухайн хичээлээ заах чадвартай, туршлагатай, мэдлэгийн түвшин шаардлага хангаж байгааг баталгаажуулсан сургалтад хамрагдсан эрх бүхий аюулгүйн хамгаалалтын зааварлагч гүйцэтгэнэ.

Анхан болон давтан сургалтын холбогдох агуулгыг тодорхойлох шаардлагатай ба агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөрт тусгасан аюулгүй байдлын тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх янз бүрийн ангилалд багтах хүмүүст зориулж боловсруулсан байна.

Сургалтын зарим асуудал нь байгууллагын бүх түвшинд ижил байж болох боловч өгөх мэдлэгийн хувьд гүн гүнзгий ялгаатай байна.

Үүний жишээ бол агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр болон ИНД-108-ийн дагуу агаарын тээвэрлэгчийн байгууллагын хүлээх хууль ёсны хариуцлага юм. Ахлах удирдах болон ахлах хяналтын албан тушаалтан нь хууль ёсны хариуцлагын талаар гүн гүнзгий мэдлэг олгох сургалтад хамрагдах шаардлагатай ба ингэснээр агаарын тээвэрлэгч байгууллагын хүлээх хариуцлагыг ойлгох үр дүнд хүрэх юм. Хүлээх хариуцлага нь бага албан тушаалтныг тэдгээрийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаанд оролцох түвшинд тааруулж сургалтад хамруулах шаардлагатай юм.

Сургалтын холбогдох агуулгыг боловсруулах, төлөвлөх, баримтжуулах энгийн бөгөөд тохирох арга бол матрицын хүснэгт ашиглах явдал юм. Энэхүү аргаар боловсруулахдаа аюулгүйн хамгаалалттай холбоотой ажилтны ангилал тус бүрийг босоо тэнхлэгт, хэвтээ тэнхлэгт шаардагдах сургалтын янз бүрийн хэсгүүдийг жагсаана. Энэ нь сургалтад хамрагдах ажилтан бүрийн сургалтын агуулгыг хялбар тодорхойлж, нийлмэл сургалтын хөтөлбөр боловсруулж болно гэсэн үг юм.

Матриц нь ангилал тус бүрд хамаарах боловсон хүчний шаардлагатай мэдлэг, чадварын журмыг тодорхойлно.

Агаарын тээвэрлэгч нь аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг бүрэн хамарсан, ажилтан тус бүрийн мэдлэг, чадварыг хангах зохих сургалтын агуулгад тохирсон хөтөлбөр боловсруулсан байна.

Хөтөлбөрийн журам бүр нь нарийвчилсан байхаас гадна тухайн журамтай холбоотой журам болон агаарын тээвэрлэгчийн хэрэгжүүлж буй аюулгүйн хамгаалалтын хяналтыг ерөнхийд нь багтаасан байна.

Ажилтны мэдлэг, чадварыг баталгаажуулахын тулд давтан сургалтыг-

- (a) зохицуулалтын шаардлага, стандартын нэмэлт, өөрчлөлт;
- (b) байгууллагын журам, хөтөлбөрийн нэмэлт, өөрчлөлт болон
- (c) байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх заналхийллийн хүчин зүйлийн нэмэлт, өөрчлөлт зэргийг багтаасан 3 жилээс хэтрэхгүй хугацаанд нь явуулна.

Агаарын тээвэрлэгч нь сургалтын үр дүнг дүгнэх зохих журамтай байна. Энэ нь үзүүлэх, тайлбарлах, шалгах гэх мэт аргаар байж болно.

Журам нь ажилтныг амжилттай сургасан эсэхийг баталгаажуулахын тулд агаарын тээвэрлэгч сургалтын хөтөлбөрт тусгагдсан чадвар тус бүрийг хэрхэн хангаж байгааг үнэлэхийг харуулна. Агаарын тээвэрлэгч нь сэдэв бүрд зориулсан ур чадварын түвшний минимум шаардлагыг тодорхойлох ба хүн бүр энэхүү шаардсан түвшинд хүрсэн эсэхийг үнэлэх ёстой.

Ур чадварын түвшний жишээ нь: Сэдэв тус бүрийг ойлгосон болон холбогдох ур чадварын түвшин дараах байдалтай байна:

- (a) Үнэлгээ 1 Сэдвийн талаарх мэдээлэлтэй;
- (b) Үнэлгээ 2 Сэдвийн талаарх үндсэн мэдлэг;
- (c) Үнэлгээ 3 тухайн этгээдийн ажил үүргийн явцад гарч болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн талаарх үндсэн мэдлэгийг ашиглах чадварыг илэрхийлдэг;
- (d) Үнэлгээ 4 тухайн этгээдийн ажил үүргийн явцад гарч болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн талаарх нарийн мэдлэгийг ашиглах чадварыг илэрхийлдэг;
- (e) Үнэлгээ 5 тухайн сэдвийн талаарх нарийн мэдлэгийг ашиглах, тухайн этгээдийн ажил үүргийн явцад гарч болзошгүй нөхцөл байдалд зөв шийдвэр гаргах чадварыг илэрхийлдэг.

### **108.60 Бүртгэл хөтлөх**

Сургалтад хамрагдах шаардлагатай хүн бүрийн үнэн зөв бүртгэлийг гаргахын тулд сургалтын бүртгэлд нэмэлт, өөрчлөлтийг хийнэ. Сургалтын бүртгэл нь сургалтад хамрагдсан бүртгэлээс илүү мэдээллийг агуулна. Тухайлбал, хамрагдсан сургалт бүрийн сэдэв, үнэлгээний аргачлал, үнэлгээ. Бүртгэл нь тухайн этгээдийн багш-зааварлагчийн талаарх бүрэн мэдээлэл болон суралцагчийн аюулгүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ойлголт, гүйцэтгэх чадварын үнэлгээг харуулна.

### 108.61 Зөрчлийг мэдээлэх

ИНД-12.55(d)(5)-д заасны дагуу зөрчлийг мэдээлэх нь үүрэг юм. ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгчийн хувьд нисэхийн аюулгүйн хамгаалалтын зөрчил нь тохиолдол бүртэй хамаатай тул мэдээлэх журамтай байна. ИНД-129-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгч нь Монгол Улсад, эсхүл Монгол Улсаас хөөрсөн нислэгт аюулгүйн хамгаалалтын зөрчил, тохиолдол гарахад мэдээлэх шаардлагатайг заасан журамтай байна.

Мэдээлэх тохиолдлын жишээ-

- (a) агаарын хөлөгтэй холбоотой хууль бус үйлдэл;
- (b) агаарын хөлөг, үйлчилгээ, эсхүл байгууламжийг заналхийлэх;
- (c) нисэн гарсны дараа энэхүү дүрмээр шаардсан аюулгүйн хамгаалалтын журмыг зөрчсөн зөрчил;
- (d) тухайн хүн хашаа аялах тухай агаарын тээвэрлэгчид мэдэгдээгүй төрийн байгууллагын зөрчил;
- (e) хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх талаар агаарын тээвэрлэгчид мэдэгдээгүй зөрчил;
- (f) нислэгт бэлтгэгдсэн агаарын хөлөгт зөвшөөрөлгүй нэвтэрсэн зөрчил;
- (g) зорчигч, эсхүл тээшинд аюулгүйн үзлэг хийхэд, эсхүл нислэгээ эхэлж буй агаарын хөлөгт үзлэг шалгалт хийхэд зэвсэг, эсхүл хэрэгсэл илэрсэн зөрчил;
- (h) агаарын тээвэрлэгчид аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх байгууллага нь ИНД-ийн дагуу үзүүлэх үйлчилгээ болон аюулгүйн хамгаалалтын үүргээ алдсан зөрчил.

### 108.63 Аюулгүйн үзлэг

Агаарын тээвэрлэгчийн хүлээсэн үүрэг болох 108.53(b)(8), 108.53(b)(9), 108.55(b)(12), 108.55(b)(16)-д зорчигч, нисэх бүрэлдэхүүн, тээшний аюулгүйн үзлэгийг ИНД-140-ийн дагуу гэрчилгээжсэн Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.

## **Хавсралт I Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага, аэродром эзэмшигч болон агаарын тээвэрлэгч нарт зориулсан тээшинд үзлэг хийх Зөвлөмжийн мэдээлэл**

### **1. Хүлээн зөвшөөрөхүйц аргачлал- Тээшний аюулгүйн үзлэг**

1.1 Зорчигчийг байлцуулан гараар үзлэг хийх.

1.2 Рентген төхөөрөмжийг тусгай зориулалтын тэсэрч дэлбэрэх бодисыг илрүүлэх систем гэж үзэхгүй. Энэ нь доор дурдсан бусад техникийн арга барилтай хамт хэрэглэгдэнэ.

1.3 Бүртгэлийн өмнө, эсхүл бүртгэлийн системгүй үед зорчигч аюулгүйн үзлэгийн ажилтанд шалгуулахаар өгсөн тээшинд рентген төхөөрөмж болон сонгон гар үзлэгийн аргыг хослуулан хийх ба тэсрэх мөр илрүүлэгч /ETD/-ийг хэрэглэж болно.

1.4 Тээш ялгах талбайд буй тээшинд рентген төхөөрөмжөөр тусгайлсан давтан үзлэгийг хийнэ. Тээш ялгах талбайд рентген төхөөрөмжөөр үзлэг шалгалт хийгдсэн тээшинд тэсэрч дэлбэрэх бодисыг илрүүлэх нохой, ETD /тэсрэх мөр илрүүлэгч/ эсхүл рентген дүрсийг 2 өнцгөөс харах төхөөрөмж зэрэг нэмэгдэл аргыг дэмжлэг болгож хэрэглэнэ.

1.5 Тэсэрч дэлбэрэх бодисыг илрүүлэх системийн ажиллагаа нь автомат горимоор ажилладаг ба аюулгүйн үзлэгийн ажилтан эргэлзээтэй тээшний рентген төхөөрөмжийн дүрсийг дүгнэж шийдвэр гаргана.

1.6 Тооцоот нислэгийн цагаас өмнө ачигдах хугацаанд дадлагажуурын өрөөнд тэсрэлтийн хүчийг саармагжуулсан тээшийг аюулгүй байдалд хадгална.

1.7 Аюулгүйн хамгаалалтын хяналтыг нэмэгдүүлсэн бусад арга хэмжээг үе үе захирал батална.

1.8 ETD системийг арчдасны горимд ашиглахдаа бусад технологи, эсхүл гар үзлэг шалгалтад туслах, дэмжлэг үзүүлэх журмаар хэрэглэнэ. Тээшинд тэсрэх хэрэгсэл агуулагдаагүй гэдгийг батлах эцсийн шийдвэр гаргахад ETD системийг хэрэглэж болохгүй. ETD-ийг шаардлагатай бол зөвхөн задалсан цүнхэн доторх онцгойлсон эд зүйл, дотор оёо болон түгжээг шалгахад ашиглана.

1.9 EDD нь цагдаагийн байгууллага болон Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын хоорондын зөвшилцсөн стандартад нийцсэн байна. EDD-г зорчигчийн мэдээлэл, рентген төхөөрөмжийн дүрсийг дахин шалгах зэрэг нийт мэдээллийн дүн шинжилгээ хийхэд хослуулан ашиглаж болно.

1.10 Монгол Улсын зохицуулалтын шаардлагыг дэмжих зорилгоор нэмэлт арга хэмжээнд үнэлгээ хийхийн тулд бусад улсаас ирүүлсэн хүсэлтийг авч үзнэ.

## **2. Татгалзсан тээш**

2.1 Аюулгүйн үзлэгийн эхний шатанд тээвэрлэхээс татгалзсан тээшийг “аюулгүй” эсхүл “сэжигтэй тээш” гэдгийг тодорхойлох хүртэл илүү нарийвчилсан арга хэмжээг авна.

2.2 Тээш зохицуулалтын систем нь аюултай, эсхүл сэжигтэй гэж тодорхойлсон тээшийг аюулгүйн үзлэгийн дараах шатанд шилжүүлэхэд, дохиоллын системийн алдаа гарсан тохиолдолд аюулгүй гэж тогтоодоогүй, эсхүл сэжигтэй цүнх тээш ялгах хэсэгт илгээгдээгүй болохыг баталгах зорилгоор тухайн системийг ажиллуулж байгаа ажилтанд сэрэмжлүүлэх дохио дамжуулахаар тохируулсан байна.

## **3. Аюулгүйн үзлэгийн бүс**

3.1 Олон улсын нислэгтэй аэродром дээр аюулгүйн үзлэгийн цэг нь өндөржүүлсэн хамгаалалттай бүсэд байрлах тул шалгагдсан тээшний аюулгүйн хамгаалалтыг хангахын тулд энгийн нэвтрэх хяналтыг нэвтрүүлсэн байна. Эдгээр бүсэд нэвтрэх хүмүүс нь нисэх буудлын анкет шалгасан эрх бүхий үнэмлэхтэй байх ба тухайн бүс рүү орохдоо шалгуулна.

3.2 Тээшний аюулгүйн үзлэгийн системийг бүртгэлийн өмнө байрлуулах бол нэмэлт шаардлага тавигдана. Нийтийн эзэмшлийн бүс болон бүртгэлийн өмнө байрлах аюулгүйн үзлэгийн өмнөх бүс хоёрын хооронд хаалт байх шаардлагатай. Энэ нь зорчигчоос бусад хүмүүс тухайн үйл явцыг харах боломжгүй хэлбэрээр зохион байгуулагдсан байна. Тухайн бүсэд зорчигч, тэдгээрийн гар тээшинд аюулгүйн үзлэг хийсний дараа аюулгүй тээшийг эрх бүхий бүртгэлийн ажилтан аюулгүйн үзлэг хийсэн байгууллагаас хүлээн авч, зорчигч тээшиндээ хүрэх боломжгүй байхаар үйл ажиллагаагаа явуулна.

## **4. Олон улсын нислэг рүү шилжүүлэх**

Олон улсын нислэгээр Монгол Улсад ирсэн тээшийг Монгол Улсаас нисэн гарах өөр олон улсын нислэгээр шилжүүлэн тээвэрлэх бол 1999 оны Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хуулийн 40.1 дэх зүйлийн дагуу дахин аюулгүйн үзлэгийн шалгалтад хамруулна. Зохих зөвлөмжийн материал нь 108.55(h)-д тусгагдсан болно.

## **5. Орон нутгийн нислэгээс олон улсын нислэг рүү шилжүүлэх**

Орон нутгийн нислэгээс олон улсын нислэг рүү шилжүүлэн тээвэрлэх тээшинд Монгол Улсаас үйлдэх олон улсын нисэн гарах нисэх буудал дээр аюулгүйн үзлэг, шалгалтыг хийнэ. Зохих зөвлөмжийн материал нь 108.55(h)-д тусгагдсан болно.

## **6. Дамжин өнгөрөх тээш**

Монгол Улсад олон улсын нислэгээр ирсэн тээшийг агаарын хөлөг түр зогсолт хийх хугацаанд агаарын хөлгөөс гаргаагүй тохиолдолд тухайн агаарын хөлөгт

аюулгүйн хамгаалалтын хүлээн зөвшөөрөхүйц шаардлагыг хангасан гэж үзэж дахин аюулгүйн үзлэгт оруулах шаардлагагүй болно.

## **7. Овор ихтэй тээш**

7.1 Зорчигчийн авч яваа болон тухайн агаарын хөлгийн зорчигчийн дагалдах овор ихтэй тээшинд аюулгүйн үзлэг хийнэ. Овор ихтэй тээшинд рентген төхөөрөмжөөр үзлэг хийхээс гадна нэмэлт, эсхүл тэсэрч дэлбэрэх бодисыг илрүүлэх нохой, ETD /тэсрэх мөр илрүүлэгч/ хэрэгслээр давхар шалгах арга хэмжээг авна.

7.2 Овор хэмжээ ихтэй тээшний хэмжээнээс хамааран рентген төхөөрөмж ашиглан аюулгүйн үзлэг хийх боломжгүй тохиолдолд тухайн тээшийг “үл танигдах ачаа” гэж тодорхойлон энэ дүрмийн 108.55(b)(6)-д заасны дагуу зохицуулна.

## **8. Илүүдэл тээш**

Илүүдэл тээш гэж агаарын тээвэрлэгчийн зөвшөөрөгдсөн жин, эсхүл хэд хэдэн тооны тээш юм. Хэрэв зорчигч нь тээшний илүүдэл жинг төлсөн бол уг тээш зорчигчтой хамт тус нислэгээр тээвэрлэгдэнэ. Хэрэв илүүдэл жинг төлөөгүй бол уг тээшийг ачаанд тооцож ачааны системийн дагуу зохицуулагдах, эсхүл тээвэрлэлтээс цуцална. Нислэгт дагалдаагүй тээшийг агаарын ачааны аюулгүй байдлын үзлэгт оруулах 108.(b)(6)-аар зохицуулна.

## **9. Нислэгийн чиглэлийн өөрчлөлт**

9.1 Нислэгийн чиглэл өөрчлөгдөж өөр газар буусан бол агаарын хөлгийн ачааны хэсэгт буй тээшийг цааш нислэг үргэлжлүүлэхдээ, тээш нь аюулгүйн хамгаалалтын түвшинг хүлээн зөвшөөрөхүйц бол дахин аюулгүйн үзлэг хийх шаардлагагүй.

9.2 Олон улсын ирэх нислэг чиглэлээ өөрчлөн өөр газар буусан үед тухайн нислэгээр аялалаа эхлэх зорчигчийн тээшинд аюулгүйн үзлэг хийнэ.

9.3 Агаарын хөлгийн ачааны хэсэгт аюулгүйн хамгаалалт хангагдаагүй, эсхүл тухайн хэсгээс буулгасан, зорчигч, эсхүл зөвшөөрөлгүй хүн нэвтэрсэн тохиолдолд тээшинд аюулгүйн үзлэгийг дахин хийнэ.

## **10. Эрт бүртгүүлсэн тээш**

Олон улсын нислэгийн бүх тээшинд аюулгүйн үзлэг хийнэ. Эрт бүртгүүлсэн тээшинд Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагаар аюулгүйн үзлэг хийлгэх зохицуулалтын арга хэмжээг зохион байгуулах үүргийг агаарын тээвэрлэгч хүлээнэ.

Агаарын тээвэрлэгч эрт бүртгүүлэх тээш хүлээн авах бол бусад аюулгүйн үзлэг хийлгэсэн тээштэй холилдохгүй байхаар тусад нь талбай гаргасан байна.

**11. Буруу чиглэлд тээвэрлэгдсэн тээш/эзэнгүй цүнх**

Буруу чиглэлд тээвэрлэгдсэн, эсхүл эзэнгүй тээш гэж тодорхойлогдсон бүх тээшийг аюулгүйн үзлэгт хамруулна.

**12. Аюулгүйн үзлэг хийсэн болон хийгдээгүй тээшнүүд холилдсон**

Олон улс болон орон нутгийн нислэгийн тээш холилдож, нэг конвейрт зөөвөрлөгдсөн бол дараах арга хэмжээг авна:

(а) Олон улсын бүртгэлийн цэг дээр хүлээн авах хугацаанд тохируулж орон нутгийн нислэгийн тээшинд аюулгүй үзлэг хийх;

(б) Тээш ялгах нэг талбай, эсхүл цуглуулах дамжуурга дээр орон нутгийн нислэгийн тээшний тусдаа дамжуурга нь олон улсын нислэгийн тээшний дамжуургатай нийлсэн бол олон улсын нислэгийн тээшийг ялгаж, аюулгүйн үзлэгт хамруулах.

**13. Тээшний аюулгүйн хамгаалалтын зүүлт**

Тээшний аюулгүйн хамгаалалтын зүүлт болон зүүлтний төхөөрөмжинд хатуу хяналт тавих шаардлагатай.

**14. Бүлэг зорчигчийн тээшний бүртгэл**

Агаарын тээвэрлэгч нь бүлэг зорчигчийн бүртгүүлсэн тээшинд тээшний зүүлт олгохын өмнө тээш тус бүрийг тодорхойлох арга хэмжээг авч, зүүлт бүрд зорчигчийн нэрийг тэмдэглэсэн байх талаар зохих журам боловсруулсан байна.

**15. Нисэх багийн тээш**

Нисэх багийн тээшийг зорчигчоос тусад нь бүртгэлийн цэг дээр бүртгэх ба нисэх багийн гишүүний нэрийг тодорхой тэмдэглэж, бүртгэлийн ажилтан нисэх багийн гишүүн бүрээр таниулсан байна. Нисэх багийн гишүүний тээшийг бусад тээшний нэгэн адил аюулгүйн үзлэгт хамруулна.

**16. Сэжигтэй тээш илэрсэн үед авах арга хэмжээ**

Нисэх буудал нь сэжигтэй тээш илэрсэн үед авах арга хэмжээний журам боловсруулж, Даргаар хүлээн зөвшөөрүүлсэн байна. Энэхүү журамд Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага, цагдаа, батлан хамгаалах, аэродром эзэмшигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын оролцоог тусгана.

**17. Аюултай бараа**

Тээшинд аюултай бараа илэрсэн үед авах арга хэмжээний журмыг Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгчийн хооронд боловсруулсан байна.

**18. Давтан үзлэгийн тогтолцоо**

Тээшний ситем /HBS/ эвдэрсэн үед тээшинд хийх аюулгүйн үзлэгийн журмыг боловсруулж Даргаар батлуулсан байна.



**19. Үзлэгийн үед тээшинд дүрс хадгалах**

Аюулгүйн үзлэгээр орсон тээшний дүрсийг нислэг гарснаас хойш 36 цаг хадгална.

**20. Чанар хяналтын явц**

Агаарын тээвэрлэгч, аэродром эзэмшигч болон Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага тээшний аюулгүйн үзлэгийн системд зохицуулалтын үйд ажиллагаа гүйцэтгэдэг бол үр дүнтэй дотоод чанарын удирдлагын хяналтын системтэй байх ба тухайн шаардлагын нийцлийг хянах аудитыг хийдэг байна.